УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГАА
СУРГАЛТЫН
ХҮРЭЭЛЭН

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХОЛБОГДОХ ЗАРИМ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА

Мэдээлэл лавлагаа
Судалгааны код: СТ-24/409

2024.08.21

Захиалагч:	УИХ-ын гишүүн С.Эрдэнэболд
Хянасан:	ПССХ-ийн захирал Ц.Цогзолмаа
Судалгаа удирдсан:	ПССХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, ахлах зөвлөх (PhD) Ц.Норовдондог
Судлаачид:	Э.Дашзэгвэ, О.Нарантуяа, П.Уранчимэг, Б.Мөнгөнсувд, Э.Билгүүн, А.Итгэл

УЛААНБААТАР
2024 ОН

АГУУЛГА

УДИРТГАЛ …….. 3

НЭГ. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТҮҮНИЙГ ХАНГАХ ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ТОЙМ МЭДЭЭЛЭЛ……. 4

1.1. Аюулгүй байдал……. 4

1.2. Үндэсний аюулгүй байдал, түүнийг хангах тогтолцоо…….…… 5

1.4. Эдийн засгийн аюулгүй байдал……..…… 8

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗАРИМ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ……..... 12

2.1. Асуудал 1……..….. 12

2.2. Асуудал 2……..... 24

2.3. Асуудал 3…… 30

2.4. Асуудал 4…… 36

2.5. Асуудал 5……..……. 41

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ ……..…….…… 42

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АУНС	Алтай-Улиастайн нэгдсэн сүлжээ
ББНС	Баруун бүсийн нэгдсэн сүлжээ
ГБҮБ	Гадаад бодлогын үзэл баримтлал
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЗБНС	Зүүн бүсийн нэгдсэн сүлжээ
ССХ	Стратеги судалгааны хүрээлэн
СЦС	Салхин цахилгаан станц
ТБНС	Төвийн бүсийн нэгдсэн сүлжээ
ТЭЗҮ	Техник-эдийн засгийн үндэслэл
УЦС	Усан цахилгаан станц
ҮАБ	Үндэсний аюулгүй байдал
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ҮАБҮБ	Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын захиалгын дагуу “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын эдийн засгийн аюулгүй байдалд холбогдох зарим зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээлэл лавлагаа”-г Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгээс хийж гүйцэтгэв.

Мэдээлэл лавлагааны захиалгын даалгавар:

“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын дор дурдсан зорилтуудын хэрэгжилтийн явц, биелэлтийн талаарх мэдээлэл лавлагаа гаргуулах. Үүнд:

1.”3.2.4.2.…2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана.”

2.”3.2.4.3.Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг багасгаж, улмаар 2020 он гэхэд дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ бүрэн хангана. Үнийн хэт хэлбэлзэлд өртөх эрсдэлээс сэргийлж,улсын нөөцийг түүхий нефтээр 6 сараас доошгүй хэмжээнд байлгана.”

3.”3.5.4.4.Түүхий нүүрсийг дулааны аргаар гүн боловсруулах, хийжүүлэх, шингэрүүлэх замаар эрчим хүч, дулааны үйлдвэрлэл, ахуйн хэрэглээний цэвэр түлш, үйлдвэрлэх аливаа үйлдвэрлэлийн технологид хэмнэлттэй, дэвшилтэт байх, шаардлагыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр дамжуулан тавина. Нар салхины сэргээгдэх эрчим ашиглалтын нэмэгдүүлж, цөмийн эрчим хүчийг ашиглана.”

4.”4.1.2.Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог нэгдмэл, үр нөлөөтэй, боловсронгуй болгох чиглэлд шаардлагатай эрх зүй, удирдлага, зохион байгуулалтын шинэчлэл хийнэ.”

5.”4.3.1.Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилтэд хяналт, дүн шинжилгээ хийх, аюулгүй байдлын нөхцөл байдалд үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтүүдийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл боловсруулна.”

6.”Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дахь Үндэсний аюулгүй байдлыг хангах арга зам, тогтолцоог хэрэгжүүлж буй нөхцөл байдал, үйл ажиллагааны уялдаа холбооны талаар төрийн холбогдох эрх бүхий байгууллагуудаас авсан арга хэмжээ, үр нөлөөний талаарх мэдээлэл”

Мэдээлэл лавлагааны зорилго: Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын холбогдох зарим зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, байдлыг холбогдох эх сурвалжийн хүрээнд тоймлон судалж, мэдээлэл лавлагаа бэлтгэх.

Мэдээлэл лавлагааны хамрах хүрээ: Энэхүү мэдээлэл лавлагаанд дурьдагдсан аюулгүй байдлын онол, ерөнхий ойлголтын талаарх тойм мэдээллийг гадаад, дотоодын судлаач, эрдэмтдийн гаргасан ном, товхимол, судалгаа, шинжилгээний материалуудын хүрээнд, холбогдох зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, байдлыг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас нийтэд ил мэдээлсэн тайлан, илтгэл, бусад материалын хүрээнд тус тус тоймлон бэлтгэсэн болно.

Захиалгын даалгаврын 4, 5 дугаар асуудлууд, ялангуяа 6 дугаар асуудал нь тодорхой хэмжээгээр төрийн болон байгууллагын нууцад хамаарах мэдээлэл байх тул манай хүрээлэнгээс эдгээр зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, байдлын талаар тодорхой мэдээллийг шаардлагын түвшинд бэлтгэн гаргах боломжгүй байна. Иймд хуулиар тухайн чиг үүргийг хариуцан хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллага болох Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба болон түүний харьяа Стратеги судалгааны хүрээлэнд тухайн асуудлаар зохих журмын дагуу хандах нь зүйтэй.

Мэдээлэл лавлагааны бүтэц: Судалгаа нь үндсэн 2 хэсэгтэй. Нэгдүгээр хэсэгт, Үндэсний аюулгүй байдал, түүнийг хангах тогтолцоо, эдийн засгийн аюулгүй байдлын талаарх ерөнхий ойлголт, олон улсын нийтлэг жишиг ба Монгол улсын бодлого, тогтолцооны талаар, Хоёрдугаар хэсэгт, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын эдийн засгийн аюулгүй байдалд холбогдох зарим зорилт, арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжилтийн явц байдлын талаарх мэдээллийг тус тус оруулсан болно.

Түлхүүр үг: *Аюулгүй байдал, Үндэсний аюулгүй байдал, Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо, Эдийн засгийн аюулгүй байдал*

Key words: *Security, National Security, National Security System, Economic Security*

НЭГ . ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТҮҮНИЙГ ХАНГАХ ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

1.1.Аюулгүй байдал

Аюулгүй байдал гэдэг нь хувь хүн, нийгэм, улс орон тодорхой аюул, занал, хор хөнөөлөөс харьцангуй ангид байх төлөв буюу өөрөөр хэлбэл тэдгээрт учрах эрсдэлийн хамгийн бага түвшнийг илэрхийлдэг өргөн хүрээтэй, олон талт ойлголт юм.[1] Түүхэн үүднээс авч үзвэл хүн төрөлхтний үүсэл, хөгжлийн бүхий л үе шатанд аюулгүй амьдрах хэрэгцээ шаардлага хурцаар тавигдаж ирсэн агаад нийгмийн хөгжил, дэвшлийг дагаад хувь хүний, бүлэг хэсгийн буюу нийгмийн, улмаар улс орны аюулгүй байдал болж цар хүрээгээ тэлсээр эдүгээ аюулгүй байдал нь дэлхий дахины шинжтэй болжээ.[2]

Аюулгүй байдлын үзэл санаа эртний хятад, грек, ром, дундад зууны болон соён гэгээрлийн үеийн сэтгэгчдийн философийн үзэл баримтлалд тусгалаа олж, философийн ухагдахуун болж төлөвшин хөгжсөөр 19-20-р зуунаас Аюулгүй байдал судлал хэмээх бие даасан салбар дундын шинжлэх ухаан болсон байдаг. Аюулгүй байдал судлал буюу аюулгүй байдлын шинжлэх ухааны хөгжил, төлөвшилд аж үйлдвэрийн хувьсгал, дэлхийн 1, 2 дугаар дайн, колоничлолын задрал, хүйтэн дайны болон түүний дараах үе, цөмийн зэвсэг бүтээгдсэн явдал, мэдээллийн технологийн дэвшил гэх зэрэг хүн төрөлхтний түүхэн дэх чухал үйл явдлууд голлох түлхэц нөлөөлөл үзүүлсэн. Аюулгүй байдлын шинжлэх ухааны түүхэн хөгжил нь хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй дэлхий ертөнцийн сөрөг тусгал болсон шинэ тутам аюул заналын шинж чанарыг танин мэдэх, тэмцэх, урьдчилан сэргийлэх, тулгамдсан сорилтуудыг шийдвэрлэж, даван туулсан замналыг харуулдаг. Өөрөөр хэлбэл уламжлалт буюу цэрэг, дайны аюул заналд төвлөрч асан цаг үеэс уламжлалт бус буюу нийгэм, улс төр, эдийн засаг, байгаль орчин, хүний олон талт хүчин зүйлст анхаарал хандуулах болсон өнөө үед ирсэн ажээ.

Орчин үед Аюулгүй байдал судлалыг “аюул заналтай тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор байгаль, нийгмийн сөрөг хүчин зүйлсээс хамгаалах, зохион байгуулах зарчим, арга, хэлбэрийг тодорхойлох замаар амьдрал, хөгжлийн тасралтгүй оршин байх нөхцөлийг хангах, энэ чиглэлээрх хууль эрх зүйн зохицуулалтыг тогтоох, тодорхойлоход чиглэгдсэн хүмүүнлэгийн, техникийн хийгээд бусад шинжлэх ухаануудын элементүүдийг агуулсан нийгмийн хавсарга шинжлэх ухааны салбар”[3] хэмээн тодорхойлж байна. Аюулгүй байдал судлалтай улс төр, цэрэг, батлан хамгаалах, эдийн засаг, түүх, социологи, соёл, хууль зүй, захиргаа, менежмент, байгаль орчин, мэдээлэл зүй, байгаль шинжлэл, техник, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, мал эмнэлэг, эрүүл мэндийн зэрэг салбар шинжлэх ухаанууд нягт уялдаж холбогддог.

Аюулгүй байдлын шинжлэх ухаан нь дараах байдлаар ангилагддаг байна. Үүнд:

1. Аюулгүй байдлын ерөнхий шинжлэх ухаан: Үүнд аюулгүй байдлын ерөнхий асуудлууд, энэ талаарх судалгааны арга зүйг хамаардаг салбарууд багтдаг. Тухайлбал: аюулгүй байдлын онол, аюулгүй байдлын шинжлэх ухааны арга зүй, аюулгүй байдлын философи, аюулгүй байдлын теологи зэрэг салбар;
2. Аюулгүй байдлын тусгай шинжлэх ухаан: Эдгээрт цэрэг, батлан хамгаалах, нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал, улс төрийн аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, нийгмийн хамгааллын аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал зэрэг салбар шинжлэх ухаанууд багтдаг.
3. Аюулгүй байдлын туслах шинжлэх ухаан: Аюулгүй байдлын онол, шинжлэх ухаанд дэмжлэг үзүүлдэг, тусгай салбар шинжлэх ухаанууд энэ ангилалд ордог. Тухайлбал: аюулгүй байдлын инженерчлэл, аюулгүй байдлын түүх, аюулгүй байдлын социологи, аюулгүй байдлын антропологи, аюулгүй байдлын удирдлага, батлан хамгаалахын удирдлага, цэргийн удирдлага, аюулгүй байдлын эрх зүй, батлан хамгаалахын эрх

[1] Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудлууд) 2022 УБ, 13 дахь тал
[2] Шинжлэх ухааны танин мэдэхүйн арга судлал Б.Өлзийхуяг, Т.Намсрай 2022 УБ, 251 дэх тал
[3] National Security Theory and Practice, Waldemar Kitler 2021 Warsaw, 71 дэх тал

зүй, цэргийн эрх зүй, хямралын удирдлага, аюулгүй байдлын боловсрол, батлан хамгаалахын боловсрол, аюулгүй байдал, батлан хамгаалахын заах арга зүй зэрэг хавсарга шинжлэх ухаанууд хамаардаг.

21-р зуунд аюулгүй байдлын тулгамдсан сорилт, асуудлууд кибер аюул занал, гибрид дайн, цаг уурын өөрчлөлт гэх мэт олон талт, нарийн нийлмэл үзэгдэл болохын хэрээр тухайн асуудлыг системийн болоод синергетик арга хандлагаар судлан шийдвэрлэх салбар дундын, даяар хамтын ажиллагаа шаардлагатай болсон байна.

Аюулгүй байдал судлалд “Аюул”, ”Занал”, ”Эрсдэл” хэмээсэн гол ойлголт нэр томьёонууд[4] хэрэглэгддэг. Эдгээр нэр томьёоны утга, агуулга, хэрэглээг танин мэдэх нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг бүрэн дүүрэн ойлгож, ухамсарлахад нэн дөхөм болгоно.

Аюул нь улс, нийгэм, хувь хүн эсхүл ямар нэгэн объект, тогтолцооны бүтэц, үйл ажиллагааг алдагдуулах хүчин зүйлийг бодитой агуулж, цаашид хохирол учруулах, улмаар устгахад хүргэх чадвар бүхий далд оршиж буй хүч юм.

Харин **Занал** нь аюул хэмээх ойлголттой төстэй боловч болзошгүй байдлаас бодитоор хэрэгжих шатандаа шилжсэн, нэг этгээдээс нөгөө этгээдэд хохирол учруулахад бэлэн болсон санаархал юм. Өөрөөр хэлбэл аюул нь тодорхой объектод шууд чиглэсэн, түүнийг онилсон хэлбэртэй болмогцоо занал, заналхийлэлд шилждэг бөгөөд аюулын үргэлжлэл, хор хохирол учруулах нь илэрхий болсон үеийн үйл ажиллагаа (процесс) юм.”.

Эрсдэл гэдгийг “Гадаад, дотоод үүдэлтэй аливаа аюул заналаас хувь хүн, нийгэм болон төр улсын хамгаалагдсан байдлын түвшнийг үлэмж хэмжээгээр бууруулж болзошгүй тааламжгүй үйл явц (хямралт үйл явдал, элдэв осол сүйрэл, байгалийн гамшиг) болон тэдгээрээс болж учрах хор хохирлын үүсэх магадлалын хослол” хэмээн тодорхойлж болно.

1.2.Үндэсний аюулгүй байдал

“Улсын аюулгүй байдал” ба “Үндэсний аюулгүй байдал”, “Үндэсний аюулгүй байдлын тогтолцоо” ба “Үндэсний аюулгүй байдлын хангах тогтолцоо” зэрэг ялгаж, салгаж ойлгох ойролцоо нэр томьёонууд бий.

“**Улсын аюулгүй байдал**” нь тухайн төр улсын оршин тогтнохтой холбоотой бол “Үндэсний аюулгүй байдал” нь түүнээс хамаагүй өргөн хүрээний ойлголт юм. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тухай хуульд тодорхойлсноор **"Үндэсний аюулгүй байдал"** гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ. “Үндэсний аюулгүй байдал” нь хувь хүн, нийгмийн амин чухал ашиг сонирхлыг хамгаалах төрийн үндсэн үйл ажиллагаа юм.

Үндэсний аюулгүй байдлын гол объект нь:

- Хувь хүн - түүний эрх, эрх чөлөө;
- Нийгэм - материаллаг болон оюун санааны үнэт зүйлс;
- Улс - түүний үндсэн хуулийн тогтолцоо, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал юм.

Үндэсний аюулгүй байдал нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: Үүнд

1. Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал;
2. нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал;
3. иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал;
4. эдийн засгийн аюулгүй байдал;
5. шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал;
6. мэдээллийн аюулгүй байдал;
7. монгол соёл иргэншлийн аюулгүй байдал;
8. хүн ам, удмын сангийн аюулгүй байдал;
9. экологийн аюулгүй байдал.

[4] Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудлууд) 2022 УБ, 17-19 дэх тал

10. хүнсний аюулгүй байдал.

Эдгээр бүрдэл хэсэг тус бүрийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь Үндэсний аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлдэг.

Аливаа тогтолцоо буюу систем нь тодорхой нэг зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд зохион байгуулагдсан элемент буюу бүрдэл хэсгүүдийн харилцан уялдаа бүхий нэгдэл байдаг. Тогтолцоо нь элемент, бүрдэл хэсэг эсхүл дэд тогтолцооноос бүрдэнэ. Тогтолцоо дараах шинжүүдтэй байна.[5] Үүнд:

- Нэгдмэл зорилготой: тогтолцоо нь тодорхой зорилго, зорилтод хүрэхэд чиглэгдсэн эсхүл тодорхой чиг үүрэг хэрэгжүүлэх үүрэг зориулалтай байна;
- Харилцан уялдаатай: тогтолцооны бүх нэгж хэсгүүд өөр хоорондоо холбоо хамаарал, харилцан нөлөөлөлтэй байна;
- Тодорхой хил хязгаартай: тогтолцоо нь гадаад орчноос зааглагдсан тодорхой хил хязгаартай байна;
- Орц, хувиргалт, гарц бүхий: тогтолцоо нь тодорхой орцуудыг боловсруулж гарц буюу үр дүнг бий болгодог;
- Эргэх холбоотой: тогтолцоо нь өөрийн тогтвортой байдлыг хадгалах, хамгаалах эсхүл гадаад, дотоод орчны өөрчлөлтөд дасан зохицохын тулд эргэх холбооны механизмыг агуулдаг.

“**Үндэсний аюулгүй байдлын тогтолцоо**“ бол үндэсний язгуур эрх ашиг сонирхол, аюул заналхийллийн харилцан үйлчлэлийг тодорхойлсон функциональ тогтолцоо байдаг. Харин “**Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо**“ бол аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүргийг төрийн бодлогын дагуу хэрэгжүүлдэг төр, засаг, төрийн захиргааны төв болон нутгийн удирдлагын төв байгууллага, тэдгээрийн мэдэлд байгаа бүтэц, хүч, арга хэрэгслийн цогц нэгдэл юм.[6]

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй дараах байгууллага байна.[7] Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах алба;
- Гаалийн алба;
- Дипломат алба;
- Гамшгаас хамгаалах алба;
- Мэргэжлийн хяналтын алба;
- Зэвсэгт хүчин, бусад цэрэг;
- Татварын алба;
- Тусгай алба;
- Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба;
- Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн алба;
- Цагдаагийн алба багтана.

Тусгайлсан чиг үүрэгтэй дээрх байгууллага, албадыг Үндэсний аюулгүй байдлыг хангах үүрэг чиглэлээр нь ангилбал:

- *Оршин тогтнохуйн аюулгүй байдал:* Дипломат алба, зэвсэгт хүчин, тусгай алба;
- *Эдийн засгийн аюулгүй байдал:*Гаалийн алба, байгаль орчныг хамгаалах алба, татварын алба;
- *Экологийн аюулгүй байдал:* Байгаль хамгаалах алба, онцгой байдлын алба;
- *Төр нийгмийн аюулгүй байдал:* тусгай алба, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба зэрэг байгууллага, албадууд хариуцна гэх зэргээр ангилж, эрх, үүргийг нь тодорхой харах боломжтой.

[5] National Security Theory and Practice, Waldemar Kitler 2021 Warsaw, 162-163 дахь тал

[6] Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудлууд) 2022 УБ, 30 дахь тал

[7] Үндэсний аюулгүй байдлын тухай хууль https://legalinfo.mn/mn/detail?lawId=18

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоонд хамаарах субъект, байгууллагуудын чиг үүрэг[8]

- *Улсын Их Хурал:* үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг тодорхойлж, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг батална.
- *Монгол Улсын Ерөнхийлөгч:* Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хувьд Үндсэн хууль, бусад хуулиар олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллаагааг ерөнхий удирдлагаар хангаж, үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар холбогдох байгууллагуудын ажилтай танилцаж, чиглэл өгнө.
- *Монгол Улсын Засгийн газар:* үндэсний аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- *Үндэсний аюулгүй байдлын зөвлөл:* үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагааг болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалтад хяналт тавина.
- *Байгаль хамгаалах алба:* хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор байгаль орчинд хортой нөлөөлөхөөс болон байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлэн хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- *Гаалийн алба:* Монгол Улсын гадаад худалдааны үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, төсвийн орлогын бүрдүүлэлт болон гаалийн хилээр нэвтрүүлэх барааны хөдөлгөөнд хяналт тавих, хилээр нэвтрүүлэх болон гаргахыг хориглосон бараа бүтээгдэхүүнд хяналт тавих, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих, гаалийн мэдээллийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах болон бусад үүргийг хэрэгжүүлнэ.
- *Дипломат алба:* Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг олон улсын харилцааны түгээмэл зарчим, эрх зүйн хүрээнд баталгаажуулах, улс орны аюулгүй байдал, үндэсний хөгжил дэвшлийг хангах таатай гадаад орчныг бүрдүүлэх, Монгол Улсын үндэсний ашиг сонирхол, байр суурь, нэр хүндийг олон улсын хэмжээнд дипломат аргаар бататган хамгаалах зэрэг үүрэгтэй болно.
- *Гамшгаас хамгаалах алба:* Үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулахуйц гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал тохиолдсон үед Монгол Улсын Их Хурал уг асуудлыг дараалал харгалзахгүйгээр нэн яаралтай хэлэлцэж, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг гаргана. Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх удирдамжийг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон болон аюулын нөхцөл байдлын талаар хүн амд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан, эсхүл шууд мэдээлэх, заавар, зөвлөмжөөр хангах болон бусад үүргийг хэрэгжүүлнэ.
- *Мэргэжлийн хяналтын алба:* Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар ноцтой аюул болон их хэмжээний хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нөхцөл байдал үүссэн тохиолдолд хяналт шалгалт явуулах үүрэгтэй.
- *Төрийн цэргийн байгуулал:* Монгол Улсын зэвсэгт хүчин улсыг цэргийн хүч, хэрэгслээр батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллага. Харин өргөн утгаараа төрийн цэргийн байгууллагууд нь эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах үүрэгтэй. Тайван цагт эх орноо гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллээс өөрийгөө хамгаалах бэлтгэлийг хангах, агаарын хилийн халдашгүй дархан байдал, агаарын зайд хяналт тавих, хамгаалах, улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх зэрэг болон бусад үүргийг хэрэгжүүлнэ.
- *Татварын алба:* Улсын төсвийн орлогыг төлөвлөсөн хэмжээнд бүрдүүлэх үүрэгтэй болно.

[8] Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудлууд) 2022 УБ, 37 дахь тал

- *Тусгай алба:* Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, тусгай албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, үндэсний аюулгүй байдлыг тагнуулын аргаар хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх үүрэгтэй.
- *Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба:* Монгол Улсад оршин суух, түр хугацаагаар зорчих гадаадын иргэдийн зохистой харьцааг бий болгох, Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсын виз, визийн зөвшөөрөл олгох, тус улсад байх визийн хугацааг сунгах, визийг хүчингүй болгох, албадан гаргах, иргэний харьяалал, цагаачлал, олон улсын болон гадаадын улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газартай холбоотой асуудлыг шийдвэрлэх, гадаадын иргэн, гэр бүлд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, илэрсэн зөрчлийг шийдвэрлэх үүргийг хэрэгжүүлнэ.
- *Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн алба:* Монгол Улс улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бүртгэлийн болон төрөлжсөн бусад байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах, Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, тэдгээрийн харьяа байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.
- *Цагдаагийн алба:* Цагдаагийн алба гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх буюу нийгмийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй болно.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо, түүний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг дараах хууль, эрх зүйн актууд болон бодлогын баримт бичгүүдээр тогтоосон байна. Үүнд:

- Үндсэн хууль (1992);
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль (2001);
- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль (1992);
- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (1994, 2010);
- Гадаад бодлогын үзэл баримтлал (1994, 2011);
- Батлан хамгаалахын Цагаан ном (2001);
- Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэс (1998);
- Батлан хамгаалах бодлогын үндэс (2015);
- Орон нутгийн хамгаалалтын тухай хууль (2018);
- Кибер аюулгүй байдлын тухай хууль (2021).

1.3.Эдийн засгийн аюулгүй байдал

Эдийн засгийн аюулгүй байдал нь тухайн улс, үндэстний төдийгүй дэлхий дахины тогтвортой байдлын тулгуур асуудал бөгөөд сүүлийн үед ач холбогдол, үр нөлөө нь дэлхийн улс орнуудын бодлогын цөм асуудал болж байна. Үндэсний аюулгүй байдлын гол бүрэлдэхүүн хэсэг болох эдийн засгийн аюулгүй байдалд нь тухайн улс орон оршин тогтнох, цэцэглэн мандах, тогтвортой хөгжихөд шаардлагатай эдийн засгийн таатай орчин, нөхцөл бүрдүүлэхээр авч хэрэгжүүлж буй төрөл бүрийн арга хэмжээ, үйл ажиллагааг хамардаг.[9] Эдийн засгийн аюулгүй байдлын үндсэн зорилго нь төр, түүний байгууллагуудаас энэ чиглэлээр үр ашигтай үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон улс орны хөгжилд саад тээг, хор хөнөөл учруулж болзошгүй гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөллийг арилгах, саармагжуулах, үр нөлөөтэй, оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлэх замаар тэдгээрээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэнэ. Эдийн засгийн аюулгүй байдлын гол асуудлууд нь:

- *Орлогын аюулгүй байдал буюу баталгаа:* Хувь хүн өөрийн болон гэр бүлийнхээ үндсэн хэрэгцээг хангахуйц хангалттай, найдвартай орлоготой байх;

[9] National Security Theory and Practice, Waldemar Kitler 2021 Warsaw, 49 дэх тал

- *Хөдөлмөр эрхлэлтийн баталгаа:* Тогтвортой, боломжийн цалинтай ажилд орох, ажлаас үндэслэлгүй халагдах болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчин алдагдахаас хамгаалуулна;
- *Нийгмийн хамгааллын сүлжээ:* Ажилгүйдлийн тэтгэмж, эрүүл мэндийн даатгал, тэтгэвэр зэрэг иргэдээ эдийн засгийн хүндрэлээс хамгаалах тогтолцоо хөтөлбөрүүд байгаа эсэх;
- *Үндсэн үйлчилгээний хүртээмж:* Боловсрол, эрүүл мэнд, орон сууц зэрэг зайлшгүй шаардлагатай нийгмийн үйлчилгээний чанар, хүрэлцээ;
- *Эдийн засгийн тогтвортой байдал:* Үнийн огцом хэлбэлзэл, ажил эрхлэлт, өсөлтөөс урьдчилан сэргийлэх эдийн засгийн тогтвортой байдлыг хангах;
- *Цочролд тэсвэрлэх байдал:* Эдийн засгийн хямрал, байгалийн гамшиг болон бусад саад бэрхшээлийг даван туулах, сөрөн тэсвэрлэх чадвар байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2 дахь хэсэгт “эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгоход оршино” хэмээн эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөлийг тодорхойлсон. Ингэснээр улс орноо тодорхой хугацаагаар тэтгэж чадах бүтэц бүхий эдийн засгийг бүрдүүлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад тогтвортой хөгжил, өрсөлдөх чадвар, олон тулгуурыг эн тэргүүнд тавьсан байна.

Эдийн засаг нь бие даасан системийн хувьд өөрийн онол, хууль, дүрэмд захирагдах боловч аюулгүй байдлын хүрээнд дэд систем болох бөгөөд системийн тогтворгүй болох нөхцөл нь дэд системээ эвдэх эсвэл дэд систем өөрөө доголдоход системээ сүйрүүлэх аюултай юм. Иймд эдийн засгийн аюулгүй байдлыг үндсэндээ гурван гол бүрэлдэхүүнд авч үзэж болно.[10]

Нэгдүгээрт, эдийн засгийн бие даасан байдал буюу хараат бус байх. Даяаршсан орчин үед улс орнууд эдийн засгийн хувьд нэг нэгнээсээ ихээхэн хамааралтай болсон үед бие даасан буюу хараат бус байдал гэдэг нь өөрийн (газар доорх болон дээрх, хүний хийгээд материаллаг) нөөцийг бие даан бүрэн хянах чадвартай, олон улсын түвшинд өрсөлдөхүйц чадвартай чанар, үр өгөөжтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж, гадаад худалдаанд энэ тэнцүү оролцох чадвартай байх, мөн шинжлэх ухаан, технологийн солилцоо, хамтын ажиллагааг тэгш эрхийн хүрээнд явагдахыг хэлнэ.

Хоёрдугаарт, үндэсний тогтвортой (даацтай) эдийн засаг. Эдийн засгийн оролцогч гишүүдийн хувийн өмчийн бүх хэлбэрийг хамгаалсан байх бөгөөд ААН, байгууллага, иргэдийн эдийн засгийн үйл ажиллагааг найдвартай, баталгаатай нөхцөлөөр хангасан байх юм. Өөрөөр хэлбэл эдийн засгийн аливаа гэмт хэрэг (авлигал, хээл хахуул, эдийн засгийн зохион байгуулалттай гэмт хэрэг зэргээс ангид, орлогын тэгш бус хуваарилалт, шударга бус байдал нь нийгмийн бухимдлыг төрүүлэн төрөл бүрийн бослого, үймээн зэрэг үүсэх эрсдэл) гаргахгүй байх нөхцөлөөр хангагдсан байх.

Гуравт, хөгжих чадвар буюу өөрөө өрийгөө хөгжүүлэх чадамж. Эрчимтэй хөгжиж буй орчин үед уг чадамж их чухал юм. Тухайлбал хөрөнгө оруулалтын таатай нөхцөл бүрдүүлэх, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, технологийг байнга шинэчлэх, инновацыг өргөн хүрээнд нэвтрүүлж байж орчин үетэй хөл нийлүүлэн алхах боломжтой юм. Мөн өндөр боловсролтой, мэдлэгтэй иргэдийг төлөвшүүлж, ур чадвартай ажиллах хүчийг бэлтгэх нь улс орны эдийн засгийн аюулгүй байдлын хангах гол хүчин зүйлс болно.

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын дээрх 3 бүрдэл хэсгийг харилцан хамаарал бүхий ”Тогтвортой хөгжил”, “Олон тулгуурт бүтэц”, “Өрсөлдөх чадвар” гэдэг ойлголтоор томьёолж байна. [11]

Тогтвортой хөгжил (Sustainable Development) гэсэн нэр томьёо анх 1987 онд “Дэлхийн хүрээлэн буй орчин ба хөгжлийн комисс” (WCED)-ийн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хуралдаанд тавьж хэлэлцүүлсэн “Бидний нийтлэг ирээдүй” (Our Common Future) илтгэлд хэрэглэгдэж, түүнээс хойш уг ойлголт, нэр томьёо олон нийтэд түгэн

[10] Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудлууд) 2022 УБ, 358 дахь тал
[11] Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудлууд) 2022 УБ, 350 дахь тал

дэлгэрчээ. Гро Харлем Брундтланд тэргүүлсэн уг илтгэл (Brundtland Report)-д тогтвортой хөгжлийг "хойч үеийнхнийхээ хэрэгцээгээ хангах чадвар, боломжийг алдагдуулахгүйгээр өнөөгийн хэрэгцээг хангах хөгжил" хэмээн тодорхойлсон. Энэхүү тодорхойлолт нь байгаль орчны тогтвортой байдлыг эдийн засгийн хөгжил, нийгмийн тэгш байдалтай холбосон олон нийтийн яриа хэлэлцээний хүрээг тодорхойлсон байна. Энэхүү үзэл баримтлал нь дотроо 2 хэсгээс буюу хөгжлийг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ дэлхийн хэмжээнд ядуурлыг бууруулахад тэргүүлэх ач холбогдол өгөх, хэрэглээг байгаль орчныг доройтуулахгүйгээр хязгаарлах гэсэн үндсэн 2 зорилтыг шийдвэрлэхэд оршино.

“Тогтвортой хөгжил” хэмээх ойлголт эдүгээ нэгэнт дэлхий дахины хэлбэрэлтгүй баримтлах үндсэн чиг хандлага болж, байгаль, экологийн тэнцвэрт байдлыг тогтвортой хадгалах явдал хүн төрөлхтний өмнө тулгарч буй нийтлэг асуудал болон тавигдаж байна. Аливаа улс орон урт хугацаанд тогтвортой хөгжих гол арга нь эдийн засгийн үйл ажиллагааг хүн, байгалийн аль алинд нь ээлтэй болгох явдал гэдгийг дэлхий нийтээр нэгэнт хүлээн зөвшөөрсөн. Энэхүү эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжлийг урт хугацаанд хадгалах “ногоон эдийн засаг”-ийн бодлогын гол цөм нь хомсдон буй нөөц баялгийг хэмнэлттэй, зохистой ашиглахад чиглэдэг. Улс орон бүр энэ чиг хандлагыг хөгжлийн бодлогодоо зайлшгүй тооцон тусгаж байна. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудаараа бидний нэрлэдэг хөдөө аж ахуй болон уул уурхайн үйлдвэрлэл болон хотжилт дагасан байгаль орчны бохирдол бидэнд “ногоон эдийн засаг”-ийн зарчмуудыг тууштай мөрдөх шаардлагыг тулгаж байна.

Олон тулгуурт бүтэц гэдэг нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1 дэд бүлэгт тодорхойлсноор “эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхыг бүрдүүлж, тодорхой салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгоно” гэж тодорхойлжээ.

Монгол Улсын эдийн засаг хэт өрөөсгөл, эмзэг бүтэц хадгалагдсан хэвээр байгаа нь нэг сул тал болж байна. Сүүлийн 20 жилийн хугацаанд эдийн засаг нэг салбарт төвлөрсөн бүтэцтэй болсон. Монгол Улсын эдийн засаг уул уурхай, тухайлбал нүүрс, зэс, төмрийн хүдэр, алт, газрын тос гэсэн цөөн тооны боловсруулаагүй бүтээгдэхүүний экспорт (байгалийн баялгийн 90 хувь) дээр тогтож байгаа ба 2023 оны байдлаар уул уурхайн салбар экспортын 93 хувь, ДНБ-ний 24 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 73 хувь, улсын төсвийн орлогын 29.0 хувийг тус тус бүрдүүлж байна. [12] Нийт экспортод эрдэс бүтээгдэхүүний эзлэх хэмжээ 1995 онд 65.5 хувь байсан бол 2023 онд 93.0 хувь болж нэмэгдсэн ба нийт экспортын 62.1 хувийг нүүрс, 18.3 хувийг зэсийн баяжмал, 5.1 хувийг алт, 3.1 хувийг төмрийн хүдэр, 2.5 хувийг газрын тос эзэлж байна. Өөрөөр хэлбэл, 2023 онд нийт экспортын 91.1 хувийг 5 төрлийн түүхий эдийн экспорт бүрдүүлж байгаа нь манай улсын экспорт нэг зах зээлд буюу уул уурхайн салбарт төвлөрч байгааг харуулж байна.[13]

Ийнхүү улсын эдийн засаг цөөн салбараас хэт хамааралтай, өрсөлдөх чадвар сул, боловсруулах аж үйлдвэр хөгжлийн хувьд хоцрогдмол, нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэггүйгээс улс орны эдийн засаг гадаад зах зээлээс хараат, цөөн бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнэ ханшаас шууд хамааралтай эмзэг, тогтворгүй байгаа нь манай эдийн засгийн аюулгүй байдал хэврэг байх гол үндэслэл болдог.

Байгалийн баялгийн эдийн засагт үзүүлэх нөлөө нэмэгдэх тусам түүхий эдийн үнэ, экспортоос хараат байдал улам ихэссэн. 2023 онд эдийн засгийн өсөлтийн хэлбэлзлийн 21 хувь нь түүхий эдийн үнээс шалтгаалж байгаа нь байгалийн баялгийн олборлолт өсөлтөд голлох нөлөөтэй хэвээр байгаа бөгөөд эдийн засагт шаардлагатай бүтцийн өөрчлөлтийг хийж чадаагүйг харуулж байна.

Эдийн засгийн өсөлт тогтворгүй байх нь цаашдын тодорхой бус байдлыг үүсгэж, эдийн засгийн үр ашгийг бууруулах, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад нөлөөлөхөөс гадна нийгмийн сайн сайхны үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлж, хөгжлийн түвшнийг бууруулж байна. Мөчлөг дагасан төсвийн бодлого хэрэгжүүлсээр ирсэн нь эдийг засагт бүтцийн шинэчлэлт хийгдэхгүй, эмзэг өрөөсгөл хэвээр байхад нөлөөлж байна.

Өрсөлдөх чадвар гэдэг нь Дэлхийн эдийн засгийн форумаас “Өрсөлдөх чадвар” гэж “Улс орны бүтээмжийн түвшнийг тодорхойлж буй институт, бодлого, дэд бүтэц гэх мэт

[12] https://mininginsight.mn/index.php?newsid=729

[13] https://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L14, Үндэсний статистикийн хороо, Гадаад худалдаа, (Татсан: 2022.09.15).

хүчин зүйлсийн нийлэмж”-ийг хэлнэ гэж тодорхойлжээ. Өрсөлдөх чадварын тухай ойлголт сүүлийн 200 орчим жилийн турш судлагдаж байгаа бөгөөд анх өрсөлдөх чадварыг туйлын давуу тал, худалдааны харьцангуй давуу талаар тодорхойлж байсан бол өдгөө боломжит нөөцөө удирдах чадвар, бизнес эрхлэх таатай орчин, эдийн засгийн салбаруудын чадавх, хөдөлмөрийн зах зээлийн байдал, төрийн тогтвортой, үр ашигтай засаглал, компанийн засаглал зэрэг гадаад, дотоод хүчин зүйлсийг нэгтгэн өргөн хүрээнд авч үзэж байна.

Монгол Улсын өрсөлдөх чадвар олон улсын түвшинд доогуур байна. Дэлхийн эдийн засгийн форумаас “Таатай орчин”, “Хүний нөөц”, “Зах зээл”, “Инновацын экосистем” гэсэн 4 хүрээнд 12 бүлгийн 103 үзүүлэлтээр Өрсөлдөх чадварыг хэмжиж байна. Монгол Улс уг Өрсөлдөх чадварын индексээр 2017-2019 онд дунджаар142 орноос 101 дүгээр байрт эрэмбэлэгддэг байсан бол 2023 оны байдлаар 35.56 оноо авч үнэлгээнд хамрагдсан 64 орноос 62 дугаар байрт орж өмнөх оноос 1 байраар ухарсан үзүүлэлттэй байна.[14] Манай орны хувьд доогуур үнэлэгдэхэд нөлөөлж буй гол хүчин зүйлс нь өмчийн эрх, засгийн газрын чиг баримжаа, тээврийн дэд бүтэц, макро эдийн засгийн тогтвортой байдал, ур чадвар, бүтээгдэхүүний зах зээлийн үр ашигтай байдал, санхүүгийн систем, бизнесийн хурдтай өөрчлөгдөх байдал, инновацын чадавх зэрэг үзүүлэлтүүд байна. Ийнхүү өрсөлдөх чадвар сул байгаа нь гадаадын хөрөнгө оруулалт доогуур, уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүн цөөн, эдийн засгийн тэлэлт удаан, нэг хүнд ногдох орлого дорвитой өсөхгүй байх гол шалтгаан болж байна.

Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд нэгдүгээрт өрийн дарамтыг бууруулж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, хоёрдугаарт, компанийн засаглалыг дэмжиж, бизнесийн орчныг сайжруулах, гуравдугаарт, тэргүүлэх салбаруудыг дэмжиж, эдийн засгийг төрөлжүүлэх, дөрөвдүгээрт, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлж, үр ашигтай үндэсний инновацын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.
Өнөөдөр улс орнуудын эдийн засгийн засгийн аюулгүй байдлын нэг тулгуур бүрэлдэхүүн хэсэг нь үйлдвэрлэл, технологи болжээ.

Түүхий эдийн экспорт давамгайлсан манай улсын хувьд аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх замаар эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, үүний тулд эрдэст түүхий эдийн боловсруулалтын түвшнийг ахиулах, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэн улс орны эдийн засгийн өсөлтийг хангах зайлшгүй шаардлага түүхийн өмнөх үеүд ч байсан, одоо ч хэвээр үргэлжилсээр байна.

[14] https://ecrc.mn/дэлхийн-өрсөлдөх-чадварын-тайлан-2023/

ХОЁР.МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗАРИМ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Асуудал 1: ”3.2.4.2. …2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана.”

Эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд эдийн засгийн аюулгүй байдлын нэг салбар нь эрчим хүчний салбар гэж тодорхойлсон. Эрчим хүчний салбар нь тухай улсын үндэсний аюулгүй байдал, бие даасан байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий тэргүүлэх салбар юм. Эрчим хүчийг боломжийн үнээр, найдвартай, үл тасалдах эх үүсвэрээс хэрэглэгчдэд хүртээмжтэй, тогтвортой хангах нь эрчим хүчний аюулгүй байдлын асуудал юм. Академич Д.Содномдорж “Монгол Улсын эрчим хүчний аюулгүй байдал” бүтээлдээ “эрчим хүчний аюулгүй байдал гэдэг нь нийгэм, төр засаг ба иргэнийг түлш, эрчим хүчний эх үүсвэрүүдийн хэвийн нөхцөлд эдийн засгийн хямд төсөр, шаардлагатай чанартай, үндэслэлтэй хэрэгцээний энергиэр хангахад дотоодын болон гадаадын хүчин зүйлүүдээс уялдан бий болох дутагдлын гаслан, мөн түлш эрчим хүчний тасралтгүй ба тогтвортой байдал алдагдахаас хамгаалагдсан байх төлөв байдлыг хэлнэ” гэж тодорхойлжээ[15].

Эрчим хүчний аюулгүй байдлыг хангах бодлогыг тодорхойлох, эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох асуудлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлжээ. Тус салбарын харилцааг дараах хууль тогтоомжоор зохицуулж байна. Үүнд:

- Эрчим хүчний тухай хууль (2001.02.01)
- Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль (2015.11.26)
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль (2007.01.11)
- “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол
- “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2010 оны 72 дугаар тогтоол
- ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол
- “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоол
- “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө” УИХ-ын 2022 оны 23 дугаар тогтоол

Монгол Улс Мянганы хөгжлийн зорилтод суурилсан “**Үндэсний хөгжлийн цогц бодлого”-**ыг 2008 оны 1 сарын 31-нд баталсан бөгөөд 2007-2015 он болон 2015-2021 он хүртэл гэсэн үндсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр баталсан. Энэхүү урт хугацааны бодлогод Монгол Улсын “Эрчим хүчний нэгдсэн систем”-ийг байгуулж, эрчим хүчний салбарын ашигт ажиллагааны түвшнийг дээшлүүлэн, хөгжлийн нэн таатай орчныг бий болгоно. Эрчим хүчний салбарыг эрчим хүч экспортолдог чадамжтай болгоно, Сум, суурин газрын болон малчдын цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулах зэрэг 4 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан.

“Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” нь 2016 онд баталсан бөгөөд уг үзэл баримтлал батлагдсанаар Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт дуусгавар буюу хүчингүй болсон. Уг үзэл баримтлалд эрчим хүчний салбарын хүрээнд эрчим хүчний хэрэгцээг дотоодын найдвартай, тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортлох, сэргээгдэх эрчим хүчний нийт эрчим хүчинд эзлэх хувийг нэмэгдүүлэх, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг ашиглах бэлтгэлийг хангах гэсэн 2 зорилтыг дэвшүүлсэн.

[15] Эрчим хүчний аюулгүй байдал, Монгол Улсын зөвлөх инженер П.Товуудоржийн илтгэлээс дам эшлэв. 2017 он https://cdn.greensoft.mn/uploads/users/1055/files/energy%20security_Tovuudorj.pdf

“Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2-т эрчим хүчний дотоодын гол эх үүсвэр болох нүүрсийг импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, орон нутагт үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байраар хангах зорилгоор өргөнөөр ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. Байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, 2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана.” гэж тусгажээ.

““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг баримт бичиг нь 3 үе шаттай хэрэгжих бөгөөд I үе шат нь 2021-2030, II үе шат нь 2031-2040, III үе шат нь 2041-2050 онд тус тус хэрэгжинэ. Тус бодлогын баримт бичигт эдийн засгийн хөгжлийг дэмжих эрчим хүч, инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх хүрээнд 2030 он гэхэд цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангана гэж, 2050 он гэхэд Эрчим хүчний бие даасан нэгдсэн системтэй болж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг хоршин ашиглах ухаалаг тогтолцоонд шилжүүлж, эрчим хүч экспортлогч улс болно гэж, мөн эрчим хүчний салбарт инновац, дэвшилтэт техник, ухаалаг технологийг нэвтрүүлж, санхүүгийн бие даасан, үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгажээ.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын эрчим хүчний сэргэлтийн хүрээнд Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлнэ, Сэргээгдэх эрчим хүчийг зохистой харьцаагаар хөгжүүлэн усан болон хуримтлуурын станц барьж, эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай, тогтвортой байдлыг хангана, Эрчим хүчний салбарыг санхүү, эдийн засгийн бие даасан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ, Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, сүлжээнд холбогдох хэт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын бэлтгэл ажлыг хангана, Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын газар нутгаар дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолойг барих бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилтуудыг тусгасан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт зааснаар Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулж УИХ-аар батлуулахаар заасны дагуу **Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө**[16]-г баталсан. Тус төлөвлөгөөнд эрчим хүчний сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд эрчим хүчний найдвартай, тогтвортой эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээг шинээр барьж байгуулах 17 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр заасан.

2015 онд УИХ-аас Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын баримт бичгийг баталсан бөгөөд 2021 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль батлагдсанаар хүчингүй болсон. Ийнхүү эрчим хүчний аюулгүй байдлыг хангах бодлогыг тасралтгүй батлан хэрэгжүүлж байна.

Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал

Монгол Улсын эрчим хүчний систем нь төвийн бүс, баруун бүс, Алтай-Улиастай, дорнод бүс, өмнөд бүсийн цахилгаан хангамж гэсэн 5 хэсгээс бүрддэг. 2024 оны байдлаар [17] эрчим хүчний системд цахилгааны эх үүсвэрийг цахилгаан станц (9), дизель станц (3), усан цахилгаан станц (7), салхины цахилгаан станц (3), нарны цахилгаан станц (9), дулааныг 14 эх үүсвэр үйлдвэрлэж хангаж байна. Монгол Улс 2023 онд[18] 10975 сая кВт/цаг

[16] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530575998941 Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө
[17] [17] https://energy.gov.mn/c/1544 Эрчим хүчний яамны цахим хуудас
[18] https://online.fliphtml5.com/seigx/vutw/#p=4

эрчим хүч хэрэглэсний 22.3%-ийг ОХУ-аас импортлон авчээ. Дотоодын эрчим хүчний хэрэглээний 7% буюу 772.6 сая кВт/цаг-ийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс, 7755.2 сая кВт/цаг буюу 71%-ийг дулааны цахилгаан станцаас хангаж байна. Мөн эрчим хүч үйлдвэрлэлийнхээ 78 %-ийг дотоодын эх үүсвэрээс, 22%-ийг хөрш орнуудаас авч байна. Үүний 58%-ийг Оюу Толгой компани БНХАУ-аас, үлдсэн 30 гаруй хувийг ОХУ-аас импортолж буй юм. "Улсын хэмжээнд ОХУ-аас 938 сая кВт.ц, БНХАУ-аас 1.5 тэрбум кВт.ц нийт 2.4 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүчийг худалдан авсан. Импортын цахилгааны төлбөрт 2023 онд 197 сая ам.доллар буюу 678 тэрбум төгрөгийн төлбөр төлсөн байна."[19]

Монгол Улсын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ 2023 онд 8,528.27 сая кВт.ц болж өмнөх оны гүйцэтгэлээс 349.7 сая кВт.ц-аар буюу 4.3%-иар өссөн ба нийт цахилгааны 90.9%-ийг дулааны цахилгааны станцаар, 8.5%-ийг нар, салхины эх үүсвэрээр, 0.6%-ийг усан цахилгаан станцаар, 0.01%-ийг дизель станцаар тус тус үйлдвэрлэжээ. 2023 онд 2,447.6 сая кВт.ц цахилгааныг импортоор авсан нь өмнөх онтой харьцуулахад 286.3 сая кВт.ц буюу 13.2%-иар өссөн байна.[20]

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээ (ТБНС)-ний дүнгээр 2023 онд 8,197.4 сая кВт.ц цахилгаан үйлдвэрлэж, 7,891.5 сая кВт.ц цахилгааныг түгээсэн нь өмнөх онтой харьцуулахад 511.1 сая кВт.ц буюу 6.9%-иар өссөн бол дулааны үйлдвэрлэл 10,712.5 мян.Гкал байгаа нь өмнөх оноос 298.4 мян.Гкал буюу 2.9%-иар өсжээ.

Баруун бүсийн нэгдсэн сүлжээ (ББНС)-ний цахилгааны хэрэглээ 2023 онд 264.87 сая кВт.ц болж, өмнөх оноос 26.8 сая кВт.ц буюу 11.2%-иар өссөн ба нийт хэрэглээний 11.6%-ийг Дөргөний УЦС, 8.2%-ийг Ховд нар НЦС тус тус үйлдвэрлэж, 80.2%-ийг ОХУ болон БНХАУ-аас импортоор хангажээ.

Зүүн бүсийн нэгдсэн сүлжээ (ЗБНС)-ний цахилгааны хэрэглээ 2023 онд 17.8 сая кВт.ц буюу 6.4%-иар өссөн. Дорнодын дулааны цахилгаан станц нь 2023 онд 249.8 сая кВт.ц, 365.9 мян.Гкал дулаан үйлдвэрлэж, 216.0 сая кВт.ц цахилгаан, 330.7 мян.Гкал дулаан түгээсэн нь өмнөх онтой харьцуулахад цахилгаан 2.5%-иар, дулаан 1.4%-иар өссөн байна.

Алтай-Улиастайн нэгдсэн сүлжээ (АУНС)-ний цахилгааны хэрэглээ 2023 онд нийт 119.5 сая кВт.ц байгаа нь өмнөх оноос 11.07 сая кВт.ц буюу 10.2%-иар өссөн ба ТБНС-ээс 861.1 сая кВт.ц эрчим хүч худалдан авсан нь 13.29 сая кВт.ц буюу 18.3%-иар өссөн бол ББЭХС-ээс худалдан аван эрчим хүч 3.9 сая кВт.ц байгаа нь өмнөх оноос 0.4 сая кВт.ц-аар өссөн бол, сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрүүд болон дизель станцын үйлдвэрлэл 29.4 сая кВт.ц болж, 2.6 сая кВт.ц буюу 8.2%-иар буурсан байна.


Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл /сая кВт.ц/[21]

Эх үүсвэр	2020	2021	2022	2023
Дулааны цахилгаан станц	6,493.6	7,109.6	7,428.5	7,755.2
Дизель цахилгаан станц	2.7	1.1	1.2	0.5
Нарны эх үүсвэр	108.9	156.9	178.7	193.0
Усан цахилгаан станц	83.3	83.1	61.7	48.1
Салхин цахилгаан станц	457.2	563.0	508.5	531.5
Нийт үйлдвэрлэл	7,145.7	7,913.6	8,178.6	8,528.3
Импорт	1,705.6	1,861.9	2,161.5	2,447.6

[19] https://news.mn/r/2744583/

[20] Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2023 УБ

[21] https://online.fliphtml5.com/seigx/vutw/#p=4



Эх сурвалж:Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2023 https://online.fliphtml5.com/seigx/vutw/#p=1

Улсын хэмжээнд эрчим хүчний системд цахилгаан болон дулаан үйлдвэрлэж буй станцуудыг авч үзвэл дараах байдалтай байна[22]. Үүнд:

Цахилгааны үйлдвэрлэл:
- “Дулааны II цахилгаан станц” ТӨХК
- “Дулааны III цахилгаан станц” ТӨХК
- “Дулааны IV цахилгаан станц” ТӨХК
- “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК
- “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК
- “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ДЦС
- “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК
- Ухаа худаг

Нарны цахилгаан станц:
- Алтай сум НЦС
- Борх НЦС /Завхан Алдархаан сум
- Цэнгэг /Улиастай хот-БХС/
- “Нар НЦС” ХХК
- “Моннаран” НЦС ХХК
- Гэгээн НЦС”
- “Сүмбэр НЦС”
- “Бөхөг НЦС”
- “Говь НЦС”

Салхин цахилгаан станц:
- “Салхит СТС” ХХК
- “Цэций СТС” ХХК
- “Сайншанд салхин парк” ХХК

Усан цахилгаан станц:
- Тайшир УЦС
- Гуулин УЦС
- Дөргөн УЦС
- Богдын гол УЦС
- Тосонцэнгэл УЦС
- Галуутай УЦС

[22] https://energy.gov.mn/c/1544 Эрчим хүчний яамны цахим хуудас


- Хүнгүй УЦС

Дулааны цахилгаан станц:

- “Дулааны II цахилгаан станц” ТӨХК
- “Дулааны III цахилгаан станц” ТӨХК
- “Дулааны IV цахилгаан станц” ТӨХК
- “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК
- “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК
- “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК
- “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК
- “БНДС” ТӨХК
- “НДС” ТӨХК
- “Дулаан шарын гол” ТӨХК
- “Хөвсгөл ДС” ТӨХК
- “Ховд ДС” ТӨХК
- “Улаангомын дулааны 2-р станц” ТӨХК
- “Амгалан ДС” ХХК

Цахилгаан эрчим хүч хэрэглэгчийн хувьд, 871,089 хэрэглэгч байгаа бөгөөд орон сууц 44.6%, гэр хороолол 45.7%, УААНБ 9.7%-ийг эзэлж байна. Бүсээр нь авч үзвэл, ТБНС 84.2%, ББЭХС 6.0%, ДБЭХС 4.0%, АУЭХС 3.1%, өмнөд бүсийн эрчим хүчний станц (ӨБЭХС) 2.6%-ийг тус тус эзэлж байна.

Цахилгаан эрчим хүчний хэрэглэгчийн тоо /бүсээр/




Эх сурвалж:Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2023: https://online.fliphtml5.com/seigx/vutw/#p=4

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ

Монгол Улсын 1000 төгрөгийн ДНБ-д ногдох цахилгаан эрчим хүчний 2015 онд 0.31 кВт.ц байсан бол 2023 онд 0.16 кВт.ц болжээ. Харин нэг ам.долларын ДНБ-д ногдох цахилгаан эрчим хүч 2015 онд 0.60 кВт.ц байсан бол 2023 онд 0.55 кВт.ц болжээ.


ДНБ-д ногдох цахилгаан эрчим хүчний хэрэглээ



Эх сурвалж:Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2023: https://online.fliphtml5.com/seigx/vutw/#p=4

Аж ахуй нэгж, байгууллагын 1000 төгрөгийн ДНБ-д ногдох цахилгаан эрчим хүч 2015 онд 0.17 кВт.ц байсан бол 2023 онд 0.09 кВт.ц болсон байна. Харин нэг ам.долларын ДНБ-д ногдох цахилгаан эрчим хүч 2015 онд 0.33 кВт.ц байсан бол 2023 онд 0.32 кВт.ц болжээ. ДНБ төгрөгөөр сүүлийн 2 жилд дунджаар 23.0-27.0 хувиар нэмэгдсэн, ам.долларын ханшийн өсөлтөөс болж ДНБ 12.0-16.0 хувиар өссөн байна.


ААНБ-ын ДНБ-д ногдох цахилгаан эрчим хүч



Эх сурвалж:Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2023: https://online.fliphtml5.com/seigx/vutw/#p=4

Айл өрхийн хувьд 2015 онд нэн өрх жилд 2.094.2 кВт.ц цахилгаан эрчим хүч хэрэглэж байсан бол 2023 онд 2,835.5 кВт.ц болсон бөгөөд өмнөх онтой харьцуулахад нэг өрхөд ногдох хэрэглээ 10%-иар буурсан байна.

Өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ кВт.ц/өрх



/өрхийн тоог ЦЭХ-ний гэрээ байгуулсан хэрэглэгчийн тоогоор тооцсон болно/

Монгол Улсад уул уурхайн томоохон төслүүд хэрэгжих нь бодитой болж, өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэглээг эрчим хүчний дотоодын эх үүсвэрээс хангах зорилгоор "Улаанбаатар ДЦС-5", "Тавантолгойн ДЦС", Дорнод бүсийн шинэ эх үүсвэр, Багануур болон нүүрсний бусад уурхайг түшиглэсэн шинэ эх үүсвэр барих асуудлыг эрчимжүүлж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн Оюутолгой уурхайн цахилгааны зарим хэрэглээг дотоодоос хангах ажлыг 2019 онд эхлүүлж 2020 оны 08 дугаар сард “ЦДҮС” ТӨХК–ийн “Оюутолгой” дэд станцын 35 кВ–ын “Оюут” А фидерээр дотоодоос цахилгаан эрчим хүчний тодорхой хэсгийг хангаж эхэлсэн.

Эрчим хүчний аюулгүй байдлыг хангах хүрээнд бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт дараах байдалтай байна.

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд эрчим хүчний чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт[23]

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжилт
1	Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийг байгуулах барилгын ажлын явц 20 хувь	“Түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжих Тавантолгой 450МВт-ын ДЦС-ын эхний ээлжийн 300МВт-ын гүйцэтгэгч болон санхүүжүүлэх эх үүсвэрийг сонгон шалгаруулах” тендерийг 2023.06.12-ны өдөр зарлаж 2023.07.27-ны өдөр нээсэн. Тендерийн хүчинтэй хугацаанд тендерт оролцогчоос 2 удаа гомдол гарсан тул үнэлгээний хорооны 2023.10.20-ны өдрийн шийдвэрээр тендер хүчингүй болсон. Төслийн бэлтгэл ажлын хүрээнд: -“Усны нөөцийн зөвлөл”-ийн 2023.07.06-ны өдрийн хурлаар станцын усны эрэл хайгуулын судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлж, БОАЖЯ-ны ТНБД-ын 2023.08.11-ний өдрийн А/248 дугаар тушаалаар Тавантолгой ДЦС-ын усны нөөцийг 25 жилийн хугацаатай үйлдвэрлэлийн С зэргээр

[23] Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд эрчим хүчний салбарын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайлан

		13л/сек буюу 1,123.2 м3/хоногоор батлуулсан. -Газрын тухай хуулийн дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах станцын нийт 90,2 га газарт Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг хийж, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраар батлуулсан. -Төслийн эхний ээлжид Тавантолгой ДЦС-Тавантолгой дэд станцтай холбогдох 21 км ЦДАШ-ын газар эзэмших гэрчилгээ авах асуудлыг Цогтцэций сумын ИТХ-ын (2023.12.14) хурлаар хэлэлцүүлж 2024 оны Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол оруулахаар дэмжигдсэн.
2	Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг өргөтгөх барилгын ажлын явц 100 хувь	Барилга угсралтын ажил (БУА)-ын гүйцэтгэл 92%, санхүүжилтийн гүйцэтгэл 65%-тай үргэлжилж байна. ЭХЯ-наас гүйцэтгэгч компанид 2024 оны 02 дугаар сард төслийг ашиглалтад оруулах үүрэг чиглэл өгсөн. Төслийн хүрээнд баригдсан 110кВ-ын хаалттай хуваарилах байгууламж, үйлдвэрийн бэлтгэл трансформатор, 0.4кВ, 6кВ хуваарилах байгууламжуудын БУА улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж 2023.12.06-ны өдөр техникийн комисс ажиллан туршилтын хүчдэлд залгасан.
3	Амгалангийн дулааны станцыг өргөтгөх барилгын ажлын явц 80 хувь	Төслийн хүрээнд 116 МВт-ын хүчин чадалтай зуух, дагалдах тоног төхөөрөмж, барилга байгууламжийн хамт хийгдэж станцын технологийн дамжлагуудад түлш дамжлагын системд вагон гэсгээгч, бутлуур суурилуулах, хими ус бэлтгэлийн хэсгийн ус зөөлрүүлэх төхөөрөмжийг 2 үе шаттай болгож техникийн ус хангамжийн чанарыг сайжруулна. Өргөтгөлийн шинэ зуухыг 2023-2024 оны өвлийн оргил ачааллын үед ажиллагаанд залгаж Улаанбаатар хотын зүүн бүсийн хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангах зорилт тавин ажиллаж, 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 82 хувийн гүйцэтгэлтэй байна.
4	Баганууурын цахилгаан станцын барилгын ажлын явц 40 хувь	БНХАУ-ын төрийн бодлоготой уялдан “Багануур пауэр” ХХК-ийн хувьцаа эзэмшигч “Цөмийн инженерийн барилга групп” ТӨХК төслийн хяналтын багц хувьцааг шилжүүлэх хүсэлтийг 2022.08.01-ний тоотоор ЭЗХЯ-д хүргүүлж, улмаар хувьцаа шилжүүлэх ажлыг 2022-2023 онд зохион байгуулж, хяналтын багцын 90%-ийг “Касень групп” компанид шилжүүлэхийг хоёр тал хүлээн зөвшөөрснөөр дахин концессын болон ЦЭХХАГ-нд зохих өөрчлөлт оруулах ажлуудыг 2023.06.05-ны өдрөөс зохион байгуулж, ЭЗХЯ-тай 2023.10.27, 2023.12.05-ны өдрүүдэд уулзалт хийсэн.
5	Дулааны II цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн хийн цахилгаан станц барих төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт 100 хувь	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2023.12.31-ний өдрөөс мөрдөгдөж эхлэхтэй холбогдуулан сонгон шалгаруулалтын ажил түр хойшилсон байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хуулийг хэрэгжүүлэх холбогдох дүрэм журмыг батлуулахаар ажиллаж байна.
6	Дулааны III цахилгаан станцыг 325 МВт-аар	Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааны Монгол, Оросын ЗГ хоорондын комиссын 24-р хуралдааны протоколын хүрээнд ЗГ

	өргөтгөх төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт 100 хувь	хоорондын хэлэлцээрийн төслийг боловсруулахаар ОХУ-ын ЭХЯ-тай хамтран ажиллаж байна. Хэлэлцээрийн төсөлд тусгах санхүүгийн нөхцөлийг тодорхой болгох зорилгоор ОХУ-ын СЯ-тай хэлцэл хийж, төслийн санхүүжилтийг шийдвэрлэж өгөх хүсэлтийг ЭХЯ-аас СЯ-д хүргүүлсэн. Санхүүжилтийн асуудлаарх хоёр улсын СЯ хооронд харилцан албан бичгийг хүргүүлсэн ба санхүүжилтийн нөхцөлийн талаар харилцан зөвшилцөлд хүрээгүй байна. Төслийн талаар ОХУ-ын ЭХЯ, СЯ-тай МУ-ын ЭХЯ-ны зүгээс 2023.02.13, 2023.02.17, 2023.06.16-ны өдөр ОХУ-д уулзалт хийж, санал солилцсон.
7	Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж байгаа дулаан, цахилгааны хэрэгцээг хангах шинэ эх үүсвэр байгуулах төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт 100 хувь	Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт 300 МВт-ын цахилгаан станцын төслийг хувийн хөрөнгө оруулалтаар “Цэцэнс майнинг энд энержи” ХХК хэрэгжүүлж байна. Эхний 150 МВт-ын блокыг 2024 онд, хоёр дахь блокыг 2025 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Станцын БУА 35%-тай, цахилгаан станцыг Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд холбох Баганаар дэд станцын өргөтгөл, “Баганаар–Бөөрөлжүүт” чиглэлийн 71.5 км ЦДАШ барих БУА, станцын хуваарилах байгууламжийн ажил хийгдэж байна.
8	Төвлөрсөн хот, сум, суурин газарт эрчим хүчний эх үүсвэр шинээр барих, өргөтгөх үйл ажиллагааны хэрэгжилт 100 хувь	-Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сумын төвийн байгууллагуудын дулаан хангамжийн систем /Хэнтий, Баян-Овоо сум/ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн барилга угсралтын ажил дуусаж 2023.12.13-ны өдөр Улсын комисс ажиллан байнгын ашиглалтад хүлээн авсан. -Халаалтын зуухнуудын төвлөрсөн дулааны холболт /Улаанбаатар/ төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэн барилга угсралтын ажил дуусаж 2023.12.08-ны өдөр ашиглалтад оруулах техникийн комисс ажилласан. Комиссын үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж байна. -Дулаан хангамжийн шугам сүлжээ, дулаан дамжуулах төв /Хэнтий, Батноров, Бэрх тосгон/ төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэн барилга угсралтын ажил дуусаж ашиглалтад оруулах техникийн комисс ажилласан, комиссын акт баталгаажих шатанд байна.
9	Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилгын ажлын явц 20 хувь	Засгийн газрын тогтоолоор төсөлд шаардагдах дотоодын санхүүжилтийг 2024 оны улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Гүйцэтгэгч компани геологи, геофизикийн судалгааны ажлыг хийсэн, зураг төсөл хийгдэж байна. ЦДАШ-ын ажил хийгдсэн. Ашиглалтын 40 км замын 10 км-т далангийн суурь тавьж, төслийн талбарт 6 км зам шинээр засаж, бараа материалын агуулах, гаалийн баталгаат агуулах, төмөр модон материал бэлдэх үйлдвэр, техник засварын цехийн талбайг бэлтгэж, үндсэн кемпийн 3 барилгыг барьж, голын түр гүүрний тулгууруудын суурийн цутгалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.
10	160 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станц барих ажлын явц	Азийн Хөгжлийн Банкны зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуур” төслийн хүрээнд “Зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралт суурилуулалт ба эхний 2 жилийн ашиглалт, үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх ажил”-ын

	100 хувь	гүйцэтгэгч (EPC) БНХАУ-ын ZTT-ZEST консорциум 2023 оны эхний улиралд зураг төслийг ажлыг дуусгаж барилга угсралтын ажлыг 2023.04.10-нд эхэлсэн. Үндсэн тоноглолууд болох батарей, эрчим хүчний хувиргуур (PCS), трансформаторууд болон бусад тоноглолуудын угсралт суурилуулалтын ажил дуусаж техникийн комисс 2023.11.10- наас эхлэн үе шаттайгаар ажиллаж, эхний тоноглол болох Сонгино дэд станцын хуваарилах байгууламжийн өргөтгөлийг 2023.11.10-нд хүчдэлд залгасан. Батарей хуримтлуурын байгууламжийг 2023.12.08-нд хүчдэлд залган цэнэглэж, 2023.12.09-өөс эхлэн хуримтлуулсан эрчим хүчийг нэгдсэн сүлжээнд нийлүүлж эхлээд байна. Туршилт тохируулгын ажил хийгдэж байгаа ба энэ хугацаанд сүлжээнд 70 МВт хүртэл чадлаар 207 МВт.ц хүртэл хэмжээний эрчим хүч нийлүүлсэн, удирдлагын системийн туршилт тохируулга, сайжруулалт хийгдэж байна. Батарей хуримтлуурын байгууламжийг хүчдэлд залгахтай холбогдон ашиглалтын талаарх сургалтуудыг явуулсан.
11	Ашиглалтад орох сэргээгдэх эрчим хүчний 10 МВт-ын станцын тоо 3.	2023 онд Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 10 МВт нарны цахилгаан станцын барилга угсралтын ажил дуусаж Техникийн комисс 2023 оны 09 дүгээр сард, Улсын комисс 2023 оны 12 дугаар сард тус тус ажилласан. Системд холбогдсоноос хойш 980,040 кВт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж 959,060 кВт.цаг цахилгаан эрчим хүчийг нийлүүлсэн. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 10МВт нарны станцын барилга угсралтын ажил 79%-тай, гэрээний дагуу 2024 онд ашиглалтад орно.
12	Эрдэнэбүрэн-Мянгад- Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих ажлын явц 30 хувь	Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 468.3 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын “Мянгад”, “Улиастай” дэд станцуудыг барих төслийг 2 үе шаттайгаар “Эрдэнэбүрэн-Мянгад”, “Мянгад-Улиастай” дарааллаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах "2022-2023 оны зээлийн төлөвлөгөөний санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр"-ийг Улсын Их Хурал 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр соёрхон баталсан. Ерөнхий хэлэлцээрийн хүрээнд Эрдэнэбүрэн-Мянгад чиглэлийн ЦДАШ барих төслийг хэрэгжүүлэх Засгийн газрын тогтоол гарсан. ЦДАШ-ын 468.3 км урт трассыг Ховд, Завхан аймгуудын ИТХ, Засаг дарга нартай хамтран ажиллаж баталгаажуулан орон нутгийн газрын албаны мэдээллийн санд бүртгүүлж, газар эзэмших гэрээг авсан.
13	Цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах "Эрчим хүчний төсөл-2" төслийн хэрэгжилт 100 хувь	Төслийн үлдэгдэл санхүүжилтээр Ховд, Увс, Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай, Баянхонгор аймгийн 20 сумын түгээх сүлжээг шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэхээр Дэлхийн банк, Сангийн яам, Эрчим хүчний яам шийдвэрлэсэн. 2023 онд “Баянхонгор эрчим хүч” ОНӨХХК, Баян-Өлгий ЦШСГ, АУЭХС ТӨХК-ууд ББЭХС ТӨХК-тай дамжуулан зээлдэх гэрээ байгуулсан. Ховд, Увс, Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай, Баянхонгор аймгийн 20 сумын 6-15/0.4 кВ-ын түгээх сүлжээг шинэчлэх ажлыг дуусгахын тулд төслийн хугацааг 5 сараар буюу 2024 оны 08 сарын 31 хүртэл

		сунгахаар Дэлхийн банк, Сангийн яам, Эрчим хүчний яам шийдвэрлэсэн.
14	Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн хэрэгжилт 60 хувь	Төслийн зөвлөхөөр Герман Улсын Integration Umwelt& Energie компани шалгаран ажиллаж байна. Барилга угсралтын гүйцэтгэгч сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2023.02.06-ны өдөр зарлаж 2023.03.31-нд нээсэн. Үнэлгээний хорооноос тендерт оролцогч компаниуд техникийн шаардлагыг хангаагүй тул бүх тендерээс татгалзах шийдвэр гарсан. Үнэлгээний тайланг KfW банкнаас хянаад "Үл татгалзах" зөвшөөрлийг 2023.06.13-ны өдөр ирүүлсэн. KfW банкны худалдан авах ажиллагааны журамд заасны дагуу тендер шалгаруулалт амжилтгүй болсон мэдэгдлийг ХБНГУ-ын Эдийн засаг хөгжлийн агентлаг (GTAI), ЭХЯ, “ЦДҮС” ТӨХК-ийн цахим хуудсаар нийтэд мэдээлсэн. Үнэлгээний хороо, Зөвлөх компани тендер амжилтгүй болсон шалтгааныг судлан тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулж KfW банкнаас “Үл татгалзах” зөвшөөрөл авсан. Олон улсын нээлттэй тендерийг 2023.08.21-ний өдөр зарлаж 2023.10.13-ны өдөр нээсэн. Тендерийн техникийн саналын үнэлгээний тайланд “Үл татгалзах” зөвшөөрөл авахаар 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр KfW банканд хүргүүлсэн. Банкнаас шалгах ажил хийгдэж байна.
15	Шинээр 10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв барих ажлын явц 70 хувь	БНСУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй 10 аймгийн төвд дулааны станц барих төслийн хүрээнд гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсан 9 аймагт барилга угсралтын ажил үргэлжлэн хийгдэж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар Багц-1 (Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Завхан) зураг төсөл, худалдан авах ажиллагаа, барилга угсралтын ажлын дундаж 42,05%, Багц-2 (Төв, Дундговь) зураг төсөл, худалдан авах ажиллагаа, барилга угсралтын ажлын дундаж 40.27%, Багц-3 (Хэнтий, Говьсүмбэр, Сүхбаатар) аймгийн барилга угсралтын ажлын дундаж 41.77%-тай тус тус үргэлжилж байна. Төслийн нийт гүйцэтгэл 40.4 хувьтай байна.
16	Хан-Уул, Баянгол дүүрэгт хэрэгжих "Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах төсөл"-ийн хэрэгжилт 60 хувь	Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2021-2025 онд хэрэгжиж буй тус төслийн хүрээнд 2023 онд дулааны 4а,б магистралийн 2Ф250/350 мм-ийн голчтой шугамыг 2Ф400 мм болгон өргөтгөж сувагт оруулах, 12г магистралийн 2Ф500мм-ийн голчтой шугамыг 2Ф700 мм-ийн голчтой болгон өргөтгөн шинэчлэх, 9а,б магистралийн Ф400/500 мм-ийн голчтой шугамыг 2Ф700 мм-ийн голчтой болгож өргөтгөх, 9ж магистралийн 2Ф250/300 мм-ийн голчтой шугамыг 2Ф400 мм-ийн голчтой болгож өргөтгөх, 5а магистралийн 800мм-ийн голчтой дулааны шугамыг 1000мм болгож өргөтгөн шинэчлэх /уурын шугамын хамт/ ажлыг тус тус дуусгаж техникийн болон улсын комисс ажиллан ашиглалтад хүлээн авсан. 2024-2025 онд шинээр хийгдэх өргөтгөл, шинэчлэлийн ажлын хүрээнд дулааны 2а магистраль шугамын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээг байгуулсан бол 9г магистраль шугамын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг зохион байгуулж үнэлсэн.

17	Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол дүүрэгт хэрэгжих "Улаанбаатарын дулаан хангамж төсөл"-ийн хэрэгжилт 70 хувь	Европын сэргээн босголт хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2021-2024 онд хэрэгжиж буй уг төслийн хүрээнд 2023 онд Насос станц №2- ын өргөтгөлийн ажлын барилга угсралтын ажлыг дуусгаж Улсын комисс ажиллан хүлээж авсан. Бичил хорооллыг дулаанаар хангах 1.3 км шугамын 1-р багц ажлын хүрээнд шугамын трасстай давхцаж байсан иргэн, аж ахуйн нэгжтэй зөвшилцөж, шугам угсралтын ажил эхэлсэн, гүйцэтгэл 60%-тай байна. 2-р багц ажлын тендерийг үнэлсэн, санхүүжүүлэгч банкнаас үл татгалзах хүлээгдэж байна. Алсын удирдлага, хяналтын системтэй цахилгаан активатор бүхий бөмбөгөн хаалт суурилуулах, Амгалан орчмын дахин төлөвлөлтийг хангах дулааны шугам шинээр татах /2Ф400мм, 1.8 хос.км/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг тус тус зарласан, 2024 оны 1 дүгээр сард нээнэ. Толгойт орчмын төлөвлөлтийг хангах дулааны шугам шинээр татах, Хэрэглэгчийн төлбөр тооцоонд ашиглах ухаалаг тоолуур суурилуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороодыг тус тус байгуулсан, ажлын тоо хэмжээ, техникийн шаардлага боловсруулах, тодотгох зэрэг ажлууд хийгдэж байна.

Асуудал 2: ”3.2.4.3. Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг багасгаж, улмаар 2020 он гэхэд дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ бүрэн хангана. Үнийн хэт хэлбэлзэлд өртөх эрсдэлээс сэргийлж, улсын нөөцийг түүхий нефтээр 6 сараас доошгүй хэмжээнд байлгана.”


Монгол Улс 1920-иод оноос газрын тосны бүтээгдэхүүн хэрэглэж эхэлсэн талаар түүхэн баримтууд байдаг бөгөөд БНМАУ-ын Ардын Сайд нарын зөвлөлийн 1941 оны 02-р сарын 28-ны өдрийн “Союзнефтьэкспорт нэгдлийн төлөөлөгчийн газраас зарим барилга байгууламж, техник тоног төхөөрөмжийг шилжүүлэн авах тухай” 15 дугаар тогтоолын дагуу тухайн үеийн Тээврийн яамны харьяанд Нефть тосны зүйлүүдийг борлуулах ажлыг эрхлэх хэлтэс байгуулснаар эхэлсэн газрын тосны салбар 83 жилийн түүхтэй.

Зүүнбаян, Цагаан-элсний орд газруудыг түшиглэн Зүүнбаянгийн газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулан 1949 онд ашиглалтад оруулсан бөгөөд 1950-1969 оны хооронд 500 гаруй мянган тонн газрын тос олборлож, боловсруулан улсын түлш, шатахууны хэрэглээний тодорхой хувийг хангаж байжээ.

Монгол Улсад 1990-ээд оноос газрын тосны хайгуулын ажил дахин идэвхтэй өрнөж, үе үеийн Засгийн газрууд түлш, шатахууны гадаад хамаарлаас ангижрах, нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдолтой Газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулахыг зорьж үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусгаж ирсэн.[24]

1.Монгол улсын газрын тосны геологийн хайгуул судалгаа, нөөц

Монгол Улсын хэмжээнд газрын тосны хэтийн төлөв бүхий хайгуулын 39 талбай ялгаснаас одоогийн байдлаар 4 талбайд газрын тосны ашиглалт олборлолтын, 9 талбайд газрын тосны хайгуулын, 6 талбайд уламжлалт бус газрын тос (нүүрсний давхаргын метан хий)-ны хайгуул, судалгааны ажлыг Засгийн газраас эрх олгосны дагуу Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу явуулж байна.



Сүүлийн 30 орчим жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн газрын тосны хайгуул, судалгааны ажилд 4.6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг зарцуулж, хайгуулын ажлын үр дүнд нийт 332.64 сая.тн газрын тосны баталгаат нөөц, 43.258 сая.тн ашиглалтын баталгаат нөөцийг тогтоож, Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэн

[24] https://mmhi.gov.mn/мэдээ-мэдээллүүд/page/2/ татсан: 2024.08.15

авсан. Өнгөрсөн 1996-2023 онуудад Тосон-Уул, Тамсаг, Зүүнбаян, Цагаан Элсний орд газруудаас нийт 10.4 сая.тн газрын тос олборлож, экспортлон, экспортын орлогоос бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу улсын төсөвт 2.5 их наяд төгрөгийг төвлөрүүлсэн байна.[25]

2.Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн хэмжээ, өнөөгийн байдал

Өдгөө манай улс газрын тосны бүтээгдэхүүнийхээ хэрэгцээг импортоор хангаж байгаа бөгөөд жил бүр өсөн нэмэгдэж буй хэрэглээг импортлогч, борлуулагч аж ахуйн нэгжүүд улсын хэмжээнд тархан байрших агуулах, түгээх станцын сүлжээгээрээ дамжуулан хэрэглэгчдэд тасралтгүй, тогтвортой нийлүүлэн ажиллаж байна. Мөн өсөн нэмэгдэж буй газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг тогтвортой, найдвартай хангах, импорт нийлүүлэлтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, тогтворжуулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.[26]

Газрын тос боловсруулах үйлдвэр

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах” төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нь 2017 оны 4 дүгээр сард Засгийн газрын 2017 оны 92 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 108 дугаар тогтоолоор байгуулагдсан. Засгийн газрын 2018 оны 323 дугаар тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэгчээр УУХҮЯ-ыг тогтоож байсан бөгөөд Засгийн газрын 2023 оны 82 дугаар тогтоолоор компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр “Эрдэнэс Монгол” ХХК-ийг тогтоосон.

Тус үйлдвэрийн үндсэн өгөгдөл:

Хүчин чадал: Жилд 1,5 сая тн тос боловсруулах
Үйлдвэрийн байршил: Дорноговь аймаг, Алтан ширээ сум
Боловсруулах тос: Тосон уул XIX болон Тамсаг XXI талбайн тос
Бүтээгдэхүүний чанар: MNS& EURO V
Жилд ажиллах хугацаа: 8000 цаг
Гүн боловсруулалтын технологи: Гидрокрекинг+Висбрекинг
Эрчим хүчний эх үүсвэр: ДЦС 35 МВт/цаг
Үйлдвэрээс гарах бүтээгдэхүүн:

- ШШХ 43 мянган тонн
- Авто бинзен 396 мянган тонн
- Дизель түлш 824 мянган тонн
- Онгоцны түлш 80 мянган тонн
- Зуухны түлш 47 мянган тонн

Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг 4 үе шаттайгаар төлөвлөн гүйцэтгэлийн ажил явагдаж байна.[27] Тус үйлдвэр ашиглалтад орсноор Монгол Улс газрын тосны бүтээгдэхүүний нийт хэрэглээнийхээ 50 гаруй хувийг хангах боломж бүрдэх юм.

Монгол Улсын Засгийн Газрын хуралдаанаар ирэх жилийн газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг ирэх онд бүрдүүлэх нэр бүхий аж ахуйн нэгж, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг хэлэлцэн баталж, Энэ дагуу аж ахуйн нэгжүүд нөөцийг 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээнд хүргэж бүрдүүлэх үүрэг хүлээж байна.

[25] https://mmhi.gov.mn/мэдээ-мэдээллүүд/page/2/ татсан: 2024.08.15
[26] https://mrpam.gov.mn/news/2469/ татсан: 2024.08.15
[27] https://mongolrefinery.mn/ татсан: 2024.08.15

Газрын тосны бүтээгдэхүүний импортын хувьд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 07 дугаар сарын 29-ний өдөр хүртэлх хугацаанд нийт 1,593.2 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон ба үүнээс: А-80 автобензин 3.7 мян.тн, АИ-92 автобензин 489.0 мян.тн, АИ-95/98 автобензин 12.9 мян.тн, Дизель түлш 921.5 мян.тн, ТС-1 /онгоцны түлш/ 50.3 мян.тн, Жет А-1 түлш 13.9 мян.тн, бусад бүтээгдэхүүн 101.7 мян.тн газрын тосны бүтээгдэхүүнийг тус тус импортолсон байна.[28]



Эх сурвалж: Ашигт малтмал газрын тосны газрын албан мэдээ

Ашигт малтмал , газрын тосны газрын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсийн дарга Д.Даваабаярын 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн ярилцлагад:



[28] https://mrpam.gov.mn/article/94/ татсан: 2024.08.15

Манай улс шатахууны хэрэглээнийхээ 70 хувийг ОХУ-ы “Роснефть” компаниас авдаг. 30 хувийг Оросын бусад компаниас авдаг байсан бол нэмэлтээр Хятад улсаас авах хэмжээгээ нэмэгдүүлсэн.[29]

Монголын шатахуун хэрэглэгчдийн холбооны гүйцэтгэх захирал Б.Сайнбаярын 2024 оны 07 дугаар сарын 29-ий өдрийн ярилцлагад:

“Монгол Улсын шатахууны жилийн хэрэглээ 2 сая 400 мянган тонн ба шатахуунаа гадаадаас импортоор авдаг. Нийт нефтийн таталтын 91 хувийг хувийн компаниуд буюу ченжүүд хийж байна. Шатахууны заавал байх нөөц 150 мянган тонн. Гэтэл Засгийн газрын нөөцлөх боломж нь 11 мянган тонн. Хэрвээ хувийн компаниуд шатахуун татахаа зогсоовол Монгол Улсад тэг зогсолт үүснэ. Тийм учраас шатахууны агуулах барих шаардлагатай. Шатахуун хомсдоод ирэхээр бүх өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгддэг. Үйлдвэр барихаасаа өмнө нөөц бүрдүүлэлт дээр анхаармаар байна. 2021 оны гуравдугаар сарын 21-ний өдөр Засгийн газрын тогтоол гарч Монгол Улсад шатахууны нөөц бүрдүүлэх журам баталсан.Гурван сарын хэрэглээг хангах боломжтой нөөцийн сав барих шаардлагатай”[30]

Шатахууны үнийн асуудал болон Монгол Улс хэджинг (Hedging) хийхэд бэлэн эсэх талаарх судалгааг хийсэн ХААИС-ийн багш, эдийн засагч Ж.Баттулгын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн ярилцлагад:

Монгол Улс газрын тосны нийт 330 сая тонны нөөцтэйгөөс баталгаажсан нөөц нь 43 сая тонн. Одоогоор ашиглалтын гурван талбайтай. Манай улс жилдээ 1-1.2 сая тонн түүхий тос олборлон экспортолж, дунджаар 390 орчим сая долларын орлого олдог.
Гэсэн хэдий ч бид дотооддоо газрын тосны бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэргүйгээс 100% гаднаас худалдан авч байгаа.
Манай улсын шатахууны зах зээл нь дэлхийн газрын тосны үнээс шууд хамааралтай юм. Бид ОХУ-аас шатахуунаа худалдаж авдаг ч Сингапурын биржийн 28 хоногийн дундаж үнээр тооцож, ам.долларoор худалдан авдаг. Иймд дэлхийн зах зээл дээрх шокуудын нөлөө шууд тусдаг гэж ойлгож болно.

Өнөөдөр дунджаар шатахууны нөөц төрөл тус бүр дээр 30 орчим хоногийн нөөцтэй байдаг. Энэ нөөцийг хувийн хэвшил дангаараа бүрдүүлж байгаа. Хэрэв бид 90 орчим хоногийн нөөцтэй байж чадвал үнийн хэлбэлзэлд ч хариу үйлдэл үзүүлэх хугацаа гарч ирж байгаа юм. 2008 оноос хойш уг нөөцийг бүрдүүлдэг болсон. Энэ нөөц бол шатахууныг тасалдалгүй, нийлүүлэлтийг хэвийн байлгах зорилготой.

Улс нөөц бүрдүүлэх бол нэмж 60 хоногийн нөөцийг бүрдүүлэх савтай болгох хэрэгтэй. Шатахууны нөөцийн сав барих нь мөн өртөг зардал их байхаас гадна 5-6 жил шаарддаг тооцоо байдаг. Иймд гадаадын зарим улсаас нөөцийн сав түрээслэх хувилбар байж болно. [31]

Газрын тосны бүтээгдэхүүний салбарын статистик мэдээлэл 2024 I-III[32]

- 2024 оны эхний 3 сарын байдлаар 1,087.5 мян.бар газрын тос олборлосон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 118.5 (9.8%) мян.бар-аар буурсан байна.
- 2024 оны эхний 3 сарын байдлаар 82.6 сая ам.долларын 1,051.4 мян.бар газрын тос экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 108.3 мян.бар буюу 9.3 хувиар, үнийн дүнгээр 5.9 сая ам.доллар буюу 6.7 хувиар тус тус буурсан байна. Газрын тосыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.
- Нийт импорт 2024 оны эхний 3 сарын байдлаар 2,414.3 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 474.6 сая ам.доллар буюу 24.5 хувиар өссөн байна. Үүнээс, Эрдэс бүтээгдэхүүний импорт 624.5 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 140.5 сая ам.доллар буюу 29.0 хувиар өссөн байна.

[29] https://gogo.mn/r/ed3d9 татсан: 2024.08.15
[30] https://news.mn/r/2741444/ татсан: 2024.08.15
[31] https://ikon.mn/opinion/1rsg татсан: 2024.08.15
[32] https://mmhi.gov.mn/ татсан: 2024.08.15

- Эрдэс бүтээгдэхүүний импортын үнийн дүнгийн 89.2 хувийг газрын тосны бүтээгдэхүүн эзэлж байна.
- 2024 оны эхний 3 сарын байдлаар 557.1 сая ам.долларын 668.4 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 178.1 мян.тн буюу 36.3 хувиар, үнийн дүнгээр 133.9 сая ам.доллар буюу 31.6 хувиар тус тус өссөн байна.
- Газрын тосны бүтээгдэхүүний импортын нийт үнийн дүнгийн 90.5 хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний 30.0 хувийг автобензин, 60.5 хувийг дизель түлшний импорт тус тус эзэлж байна.
- 2024 оны эхний 3 сарын байдлаар 167.0 сая ам.долларын 230.1 мян.тн автобензин импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 73.0 мян.тн буюу 46.5 хувиар, үнийн дүнгээр 52.1 сая ам.доллар буюу 45.3 хувиар тус тус өссөн байна.
- 2024 оны эхний 3 сарын байдлаар 337.2 сая ам.долларын 392.3 мян.тн дизелийн түлш импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 76.3 сая ам.доллар буюу 29.2 хувиар, биет хэмжээгээр 99.5 мян.тн буюу 34.0 хувиар тус тус өссөн байна.

Асуудал 3: ”3.5.4.4. Түүхий нүүрсийг дулааны аргаар гүн боловсруулах, хийжүүлэх, шингэрүүлэх замаар эрчим хүч, дулааны үйлдвэрлэл, ахуйн хэрэглээний цэвэр түлш, үйлдвэрлэх аливаа үйлдвэрлэлийн технологид хэмнэлттэй, дэвшилтэт байх, шаардлагыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр дамжуулан тавина. Нар салхины сэргээгдэх эрчим ашиглалтын нэмэгдүүлж, цөмийн эрчим хүчийг ашиглана.”

Манай улсын нүүрсний геологийн нийт нөөцийг 150 тэрбум тонн гэж тогтоосон бөгөөд 22.3 тэрбум тонн нүүрсний нөөцийг урьдчилсан болон нарийвчилсан хайгуулын үр дүнгээр баталгаажуулаад байна. Монгол улс нүүрсний нийт нөөцөөр дэлхийд эхний 12-т, нэг хүнд ногдох нөөцөөр эхний 4-т ордог. Нүүрсийг үндсэндээ эрчим хүчний үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болгон ашиглаж байна. Улсын хэмжээний цахилгаан дулаан үйлдвэрлэлийн 93%-ийг нүүрсэнд, 7%-ийг шингэн түлшинд тулгуурлан үйлдвэрлэж байна.[33]

Цаашид нүүрсний үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах асуудлыг нэн түрүүнд тавих, нүүрсийг түлшний зориулалтаар ашиглахаас гадна нүүрсийг баяжуулах, хийжүүлэх, шингэрүүлэх, нефтийн бүтээгдэхүүн гаргах, нүүрсийг коксжуулах замаар дайвар бүтээгдэхүүн гарган авах, чанар сайтай нүүрсийг экспортод гаргах зэрэг өргөн цар хүрээтэй асуудлууд гарч байна.

Нүүрсний томоохон үйлдвэрлэгч болох Хятад, АНУ, Австрали, Энэтхэг зэрэг улсуудад өндөр хүчин чадалтай нүүрс баяжуулах үйлдвэрүүд шинээр ашиглалтад орохын зэрэгцээ хуучин баяжуулах үйлдвэрүүдийн техник технологийг боловсронгуй болгож байна.

Монгол Улс энэ чиглэлээр ямар үйл ажиллагаа явуулж байгааг дор дурдвал:

1. Устөрөгчийн үйлдвэрлэл ба дагалдах бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн төсөл

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2022 оны 11 сарын 29-нөөс 02 сарын 2-нд Япон Улсад айлчилсан байна. Айлчлалын хүрээнд Токио хотноо болсон Монгол Японы Төр, хувийн хэвшлийн Х зөвлөлдөх уулзалтад Ерөнхийлөгч У.Хүрэлсүх оролцсон. “Манай орны ашигт малтмалын баялаг нөөцийг Японы дэвшилтэт техник технологитой хослуулан устөрөгчийн үйлдвэр ба дагалдах бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн төслийг хоёр улсын хувийн хэвшлийн байгууллагууд хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байгааг Монголын тал бүх талаар дэмжинэ. Энэхүү төсөл хөтөлбөр хэрэгжсэнээр ногоон эрчим хүч болон химийн үйлдвэрлэлийн салбарт хоёр орны хамтын ажиллагаа шинэ шатанд гарч, өргөжин хөгжинө гэдэгт итгэлтэй байна” гэж хэлсэн нь айлчлалын протоколд тэмдэглэгджээ. 10 дугаар зөвлөлдөх уулзалтын үеэр Монголын бизнес эрхлэгчид Японы компаниудтай 6 томоохон гэрээнд гарын үсэг зурсны нэг нь дээрх устөрөгчийн үйлдвэрийн төсөл юм. Төслийн хүрээнд нүүрс-химийн үйлдвэрлэлийг Монголд хөгжүүлэх чиглэлээр томоохон судалгаа, ТЭЗҮ-ийг боловсруулах ажил эхлүүлэхээр талууд тохиролцоод байна. Бизнес уулзалт дээр “Монголын Алт” ХХК-ийн төслийн багийн гишүүн Х.Базарханд “Устөрөгчийн үйлдвэрлэл ба дагалдах бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн төсөл”-ийг танилцуулжээ.

Манай улсын хувьд их хэмжээний хүрэн нүүрсний нөөцөө хийжүүлж ашиглах, шингэн түлш үйлдвэрлэх асуудал цөөнгүй жил яригдаж байна. Ялангуяа Тавантолгой, Шивээ-Овоогийн нүүрсний орд дээр төрөл бүрийн хувилбарууд дэвшүүлсээр ирсэн. Мөн “Эрдэнэс Тавантолгой”-н хувьд коксжих нүүрстэй хамт олборлогддог их хэмжээний эрчим хүчний нүүрс борлуулалтгүй овоологдсоор байгаа. Үүнийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь зайлшгүй шийдэх ёстой тулгамдсан асуудлын нэг болоод байна.[34]

2. Нүүрс шингэрүүлэх технологийн дараагийн шат буюу хийжүүлэх технологи

Монголд олборлож буй нүүрсийг цэвэр нүүрсний технологиор гүн боловсруулж, дулаан, цахилгааны эрчим хүчний дутагдлыг бүрмөсөн шийдээд зогсохгүй, өндөр үнээр экспортлох боломж байна. Дорнод аймгийн төвийн ойролцоох Адуунчулууны уурхайн нүүрс

[33] ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал газрын тосны газар https://www.mrpam.gov.mn/news/1378/ татсан: 2024.08.15

[34]Mining insight Magazine https://mininginsight.mn/index.php?newsid=585 татсан: 2024.08.15

хийжүүлэхэд тохиромжтой, устөрөгчийн гарц өндөр болох нь тогтоогдсон бөгөөд “Монголын Алт” МАК ХХК өнгөрсөн жилийн намраас хойш Японы эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран, Монголд хэд хэдэн нүүрсний орд дээр хийжүүлэлтийн идэвх тодорхойлох судалгаа явуулахад Адуунчулууны нүүрс онцгой сайн үзүүлэлттэй гарчээ. Иймд судалгаагаа үргэлжлүүлж, Япон улсын “Unico International Corporation”-тай хамтран, туршилтын үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах хэлэлцээрт хүрээд байгаа юм.

Урьдчилсан төлөвлөгөөгөөр туршилтын үйлдвэрийг хоёр үе шаттай байгуулна. Эхний үе шатанд нүүрснээс диметилийн эфир гэх бодис гаргаж авна. Энэ нь дулааны найдвартай эх үүсвэр болох боломжтой. Диметилийн эфирийг оргил ачааллын үеэр хийн түлшээр ажиллахаар төлөвлөгдсөн дэд төвүүдэд нийлүүлнэ. Мөн Улаанбаатар хотын дулааны нэгдсэн сүлжээнд холбогдоогүй халаалтын зуухнуудыг хийн халаагуурт шилжүүлж, диметилийн эфирээр хангана. Товчоор хэлбэл, өнөөдөр агаарын бохирдол бий болгогч гэж ад үзэгдсэн нүүрс “маргааш” агаар цэвэршүүлэх гол шийдэл болохоор байна. Түүнээс гадна диметилийн эфир үйлдвэрлэх явцад бий болох нүүрстөрөгчийн давхар ислийг газрын тос болон байгалийн хий олборлох цооног руу шахаж оруулах замаар олборлолтыг нэмэгдүүлэх боломжтой гэнэ.

Хоёрдугаар шатанд устөрөгч үйлдвэрлэж, Япон болон Зүүн Азийн орнуудад экспортлохоор төлөвлөжээ. Адуунчулууны нүүрсний орд нь зүүн хилд ойр байрладгаараа давуу талтай. Ердөө 1500 гаруй км тээвэрлээд, БНХАУ-ын Жинжоу далайн боомтод хүрэх боломжтой. Үүнээс цааш хямд зардлаар буюу усан замаар 2480 км-ийг туулан, Японы зах зээлд нэвтэрнэ. Устөрөгч гарган авснаар дотооддоо дизель, бензин, тос, тосолгооны материал үйлдвэрлэж болох химийн үйлдвэрлэлийн суурь тавигдах боломжтой.[35]

3. Нүүрсний хаягдлыг эко хөрс болгох технологи

Нүүрсний уурхайн хаягдал чулуулгаас хөрс боловсруулан, экологийн цэвэр бүтээгдэхүүн гаргах технологийг Монгол Улс, БНХАУ-ын эрдэмтэд хамтран боловсруулжээ. Тодруулбал, нүүрсний уурхайнуудын хаягдал нүүрсийг хөрс болгох судалгааны төсөл дуусаж, нийслэлийг эрчим хүчээр хангах Бөөрөлжүүтийн цахилгаан станцад туршиж эхэлжээ. Нүүрсний хаягдал чулуулгаас гарган авсан хөрсийг уул уурхайд байгалийг нөхөн сэргээхэд эргэж хэрэглэх, мөн газар тариаланд бордоо хөрс байдлаар ашиглах боломжтой. БНХАУ-ын Шанси муж нүүрсний орд ихтэй бөгөөд хаягдал чулуулгаас хөрс, бордоо гарган авах технологийг нэлээн хэдэн жил туршиж хэрэглэсэн туршлагатай. Энэ технологийг үйлдвэрлэлийн хамт Монгол Улсад шилжүүлж, хэрэгтэй бүтээгдэхүүн гарган авахад хамтран ажиллахаар болж байна. ХААИС-ийн ректор, профессор Б.Баасансүх хэлэхдээ, “Энэ бол уул уурхайн салбарыг түшиглэсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх эко төсөл юм. ХААИС-ийн гадаадын их, дээд сургууль, байгууллагатай хийж буй нийт 27 инновац төслийн нэгний үр дүн ийнхүү гарч байна” хэмээн онцоллоо. Төсөл хаягдал нүүрс боловсруулж хөрс бэлдэх замаар энэ талын мэргэжилтэнг БНХАУ-д бэлтгэх байдлаар 2-3 жилийн хугацаанд үргэлжлэх юм байна.

Бөөрөлжүүтийн цахилгаан станцыг “Цэцэнс майнинг энержи” компани гүйцэтгэж байгаа бөгөөд хүрэн нүүрсний ил уурхай түшиглэсэн учраас Монгол, Хятадын эрдэмтдийн судалгааны ажлыг бодит байдалд хэрэгжүүлэхээр хаягдал чулуулаг, овоолгоо бүрэн боловсруулж, хөрс, бордоо гаргаж авахаар болсон байна.[36]

4. Нүүрсний давхаргын метан хий

Дэлхийн улс орнууд метан хийг эрчим хүч, дулаан, химийн салбарт түгээмэл ашиглаж байна. Монгол улс хүлэмжийн хийг бууруулах тухай Киотогийн протоколд нэгдсэнээр тодорхой үүрэг хүлээсэн байдаг. Тиймээс бусад өндөр хөгжилтэй орнуудтай адил хүлэмжийн хийг багасгах үйл хэрэгт хувь нэмрээ оруулж, ногоон эрчим хүчийг хөгжүүлэлт хийгдэж буй энэ цаг үед хугацаа алдалгүй метан хийн хайгуулын ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.[37]

[35] Монголын уул уурхайн сэтгүүл 2023.12.05 https://www.mongolianminingjournal.com/a/73248 татсан: 2024.08.15
[36] Монголын уул уурхайн сэтгүүл 2024.07.05 https://www.mongolianminingjournal.com/a/73557 татсан: 2024.08.15
[37] https://www.mongolianminingjournal.com/a/72970 татсан: 2024.08.15

Нүүрсний давхаргын метан хийн нөөцийг тодорхойлж, олборлосноор түүхий нүүрснээс татгалзан, экологийн хувьд цэвэр түлш ашиглана. Мөн цахилгаан станц, жижиг зуух, төмөрлөгийн үйлдвэр, өндөр даацын авто машин, нийтийн тээврийн хэрэгсэл, ахуйн хэрэглээг хийн түлшээр хангаж, агаарын бохирдол буурах төдийгүй дэд бүтцийн салбарт ч чухал ач холбогдолтой. Манай улсын эрчим хүчний шинэ эх үүсвэрийн нэг хэсэг нь метан хий. Хэрвээ метан хийн нөөцөө судлахгүй байсаар цаг алдвал өөрсдөдөө байгаа үнэ цэнтэй нөөц баялгаа үнэгүй хаяж байгаагаас ялгаагүй.

Нөгөөтээгүүр метан хийг уламжлалт болон уламжлалт бус гэдгээр нь ялгах, ойлгохын зэрэгцээ хууль, эрх зүйн орчныг улам сайжруулж, газрын тосны тухай хууль болон дагалдах журам, бүтээгдэхүүн хуваах гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага тулгарч байгааг салбарын мэргэжилтнүүд тайлбарлаж байна.

Нүүрсний давхаргын метан хийн эрлийн ажлын гэрээг “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанитай Тавантолгойн нүүрсний уурхайд, “Монголын алт” (МАК) ХХК-тай Нарийнсухайтын нүүрсний орд газарт тус тус байгуулж байсан. Метан хий ашиглах боломж бүрдлээ гэхэд эхний ээлжид байгалийн хийн нөөц, ТЭЗҮ-ийг тогтоож, хийн шугам сүлжээ, насосын станцууд зэрэг иж бүрэн цогцолбор барих шаардлагатайгаас гадна мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх хэрэгтэй.

Австралийн хөрөнгийн биржид бүртгэлтэй гурван компани 2019 оноос эхлэн монгол улсад метан хийн хайгуул хийж, туршилтын цооног өрөмдөх ажлаа эхлээд байна.

“Олборлолтын туршилт” нь эдийн засгийн үр ашгийг тогтоох зорилгоор гүйцэтгэх олборлолтыг хэлдэг. Туршилтын өрөмдлөг нь одоо байгаа хийн хэмжээг ашиглахад эдийн засгийн үр өгөөжтэй эсэх, боломжит олборлолтын хүчин чадал, талбайн ашиглалтын үргэлжлэх хугацааг тогтоодог. Одоогоор зургаан талбайд дөрвөн компани бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулжээ. Эдгээр компаниуд 2018 оноос эхлэн метан хийн хайгуулын ажлыг тасралтгүй гүйцэтгэж байна.

Түүхий нүүрсийг орлох, экспортын орлогыг өсгөх метан хий ба Монголын боломж:

Нүүрсний давхаргын метан хийг дулаан, эрчим хүч үйлдвэрлэхээс гадна тээврийн хэрэгсэл, ахуйн хэрэглээнд ашиглах боломж бий. 2022 онд манай улс 290 сая ам.долларын цахилгаан эрчим хүчийг хоёр хөршөөсөө импортолжээ. Мөн шингэрүүлсэн хий болон бусад хийн байдалтай нүүрс-устөрөгчийн импорт 18 сая ам.долларт хүрсэн байна. Үүгээр тооцож үзвэл нүүрсний давхаргын метан хийн хувьд багадаа 300 гаруй сая ам.долларын зах зээл байна гэсэн үг юм. Шингэрүүлсэн хий болон бусад хийн байдалтай нүүрс-устөрөгч, цахилгаан эрчим хүчний импортыг нарийвчлан авч үзвэл:

- 2022 онд ОХУ-аас 15.1 сая ам.долларын, БНСУ-аас 3.6 сая ам.долларын шингэрүүлсэн хий болон бусад хийн байдалтай нүүрс-устөрөгч импортолжээ. Тодруулбал, ОХУ-аас нэг литр тутмыг 995 төгрөгөөр, БНСУ-аас 5206 төгрөгөөр авсан байна.

- 2022 онд БНХАУ-аас 1,454,161.38 мВт.ц эрчим хүчийг 206.9 сая ам.доллароор, ОХУ-аас 653,206.21 мВт.ц эрчим хүчийг 83.8 сая ам.доллароор импортолсон байна. Энэ нь нэг мВт.ц эрчим хүчийг БНХАУ-аас 89.7 ам.доллароор, ОХУ-аас 79.2 ам.доллароор авсан гэсэн үг. Үүнийг төгрөгт шилжүүлбэл (2023.08.25) нэг кВт.ц эрчим хүчийг урд хөршөөс 311 орчим төгрөгөөр, хойд хөршөөс 275 төгрөгөөр импортолсон байна. Он гарснаас хойш БНХАУ-аас 76.5 сая ам.доллар, ОХУ-аас 32 сая ам.долларын эрчим хүч худалдан аваад байна.

- Экспортын хувьд БНХАУ руу цахилгаан эрчим хүч экспортлох гэрээгүй учир урагшаа экспорт хийгддэггүй. Харин ОХУ руу 354 мянган ам.долларын илүүдэл эрчим хүч экспортолсон байна. Энэ нь нэг кВт.ц тутмыг 48 төгрөгөөр зарсан гэсэн үг. Манай улсын хувьд айл өрхөд нэг кВт.ц эрчим хүчийг 110-130 төгрөгөөр, уул уурхайд 105-390 төгрөгөөр борлуулж байгаа юм.

Нүүрс нь манай улсын хувьд эдийн засагт ихээхэн үүрэгтэй салбар юм. Олон улсад нүүрсний олборлолтоос жилд 52.3 сая тонн метан ялгаруулж байгаа нь газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлээс өндөр байгааг Global Energy Monitor-ын судалгаанд дурдсан

байдаг. Харин нүүрсний давхаргын метан хий нь газрын тос, байгалийн хийнээс илүү цэвэр эрчим хүчинд тооцогддог. Өөрөөр хэлбэл энэхүү урвуу хамаарлыг нүүрсээр баялаг Монгол орны хувьд тэнцвэржүүлэх шаардлагатай болж байна. Тэрхүү тэнцвэржүүлэгч нь нүүрсний давхаргын метан хийг ашиглаж байгаль дэлхийд ээлтэй хандах явдал юм.

Монгол болон Австрали улс хамтран зургаан сарын турш нөөцийн судалгаа хийсний үр дүнд Монгол Улсын нүүрсний давхаргын метан хийн боломжит нөөцийг 7.4 их наяд метр куб гэж үнэлжээ. Одоогийн байдлаар улсын хэмжээнд бүтээгдэхүүн хуваах гэрээтэй дөрвөн компанийн зургаан талбай байгаа. Түүнчлэн 2019 оноос эхлэн Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй гурван компани Өмнөговь аймгийн нутагт метан хийн хайгуул хийж, туршилтын цооногуудаа өрөмдөж байна.

Төслүүдийн ахицаас танилцуулбал “Гурвантэс XXXV” төслийг эзэмшдэг "TMK Energy" энэ оны дөрөвдүгээр сард өрөмдлөгийн хөтөлбөрөө эхлүүлж, одоогоор Нарийнсухайт хайгуулын бүсэд өрөмдсөн туршилтын гурван цооногтоо хийн тогтмол урсгал бий болгоод байна. Тус компани 2023 оны наймдугаар сард цооногуудын үйл ажиллагааг эхлүүлснээс хойш гарган авсан хийн хэмжээ нь сар бүр бараг хоёр дахин нэмэгдэж байгаа аж.

Харин “Elixir Energy” компани есдүгээр сард “Nomgon X” цооногийг амжилттай өрөмдөж, олборлолтын үйл ажиллагааг эхлүүлсэн юм. Тус компани энэ онд “Номгон” талбайн өргөтгөсөн туршилтын хөтөлбөрөө үргэлжлүүлж, нийт есөн цооног өрөмдөхөө зарлаад байна. 30 мянга орчим км.кв талбайг хамардаг “Номгон” төсөл нь Хойд Хятадын хий дамжуулах гол сүлжээнээс ердөө 400 км зайтай нь давуу тал болохыг тус компани онцолж буй.

Эцэст нь Тавантолгойн нүүрсний давхаргын метан хийн төслийг удирдаж буй “Jade Gas Holdings” компани саяхан “Баруун наран” талбайдаа 104.6 метрийн зузаантай хийтэй нүүрс илрүүлснээ мэдээлсэн юм. Цаашид тус компани тогтоосон боломжит хийн нөөцөө бататгаж, 2024 оноос эхлэн олборлохыг зорьж байгаа аж.[38]

5.Нар, салхины эрчим хүчний ашиглалт

Нар, салхины эрчим хүчний үйлдвэрлэл 2030 он гэхэд 12%-иар өсч, дэлхийн нийт цахилгаан эрчим хүчний гуравны нэгээс илүүг бүрдүүлнэ гэж эрчим хүчний шилжилтийн судалгааны байгууллага Rocky Mountain Institute (RMI) шинэ тайландаа дурджээ.[39]

Монгол Улс байгалийн асар их нөөц баялгаа ашиглаж, сэргээгдэх эрчим хүчний салбарын хөгжилд анхаарлаа хандуулбал уг салбарт ажлын байр шинээр нэмэгдэх ба гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах боломжтой. Урт хугацаандаа уур амьсгалын болон эрчим хүчний шилжилтийн улмаас бусад улс орны эрчим хүчний нүүрсний импорт буурах хандлагатай байна. Энэ тохиолдолд Монгол Улс цэнэг хураагуур үйлдвэрлэх болон эрчим хүчний бусад технологид ашиглагддаг байгалийн баялгийн олборлолт, экспортоор тэргүүлэгч улс болох боломжтой. Монгол Улсад сэргээгдэх эрчим хүчний зах зээлийг бэхжүүлэх нь эдийн засгийг төрөлжүүлэхэд нэмэр болж мөн цэвэр технологи ашиглан экспорт хийх үйлдвэрүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, эрэлт өндөртэй байгаа дэлхийн зах зээлд нийлүүлэх боломж бүрдэнэ. Үүнээс гадна, сэргээгдэх эрчим хүч ашиглах, үр ашгийг нэмэгдүүлэх нь уул уурхайн олборлох салбарыг бүтээмжтэй, хэмнэлттэй болгоход тустай бөгөөд тус салбарын өрсөлдөх чадварыг хадгалахад үр дүнтэй юм.

Баруун бүсэд Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкны нэн хөнгөлөлттэй зээл болон Япон улсын буцалтгүй тусламжийн 50:50%-ийн санхүүжилтээр Монгол Улсын Засгийн газраас сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлж байна. Алс баруун хязгаарт хувийн хөрөнгө оруулалтын өртөг өндөр дүнтэй гарсан тул хамтрагч байгууллагуудын зээл, тусламжаар хэрэгжүүлж дуусах шатандаа оржээ. Төслийн дагуу баруун бүсэд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд Ховд, Хөвсгөл аймгийн төв, Говь-Алтайн алслагдсан Алтай сум, Завханы Улиастайд төсөл хэрэгжиж байна. Мөн Хөвсгөлийн

[38] https://www.bloombergtv.mn/news/hc1s5 татсан: 2024.08.15
[39] Монголын уул уурхайн сэтгүүл 2023.07.17 https://www.mongolianminingjournal.com/a/72986 татсан: 2024.08.15

Мөрөнд нарны эрчим хүчний станцын барилга угсралтын ажил дуусах шатандаа ороод байна. Эдгээр төслүүдийн тулгамдсан асуудал нь дээр өгүүлсэн нар, салхи бол тогтвортой эх үүсвэр биш гэдэг асуудал. Хүйтний эрч чангарахын хэрээр салхины эх үүсвэр мөн саарч, хүндрэлтэй тулгардаг.

Салхины станцын тухайд ч ялгаагүй. Монголд хоногийн 24 цаг салхилах нь ховор бөгөөд нарны станц шиг хоногийн тэр цагт салхин станцын үйлдвэрлэл нэмэгдэнэ, багасна гэж тооцоолох боломжгүй, хэлбэлзэл үүсдэг байна. “Салхилсангүй” гээд цахилгаан таслах биш, эрчим хүчний систем эрчим хүчээр тогтвортой хангаж байх ёстой.

Эрчим хүчний оргил ачааллын үеийн доголдлыг дараах байдлаар шийдэх боломжтой:

- том, дунд чадлын усан цахилгаан станц;
- усан цэнэгт буюу ус хуримтлуурын усан цахилгаан станц;
- хийн цахилгаан станц;
- сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа батарей хуримтлуурын станц манай оронд тохиромжтой аж. Бусад улс орнууд ч ийм шийдлүүдээр хэлбэлздэг эх үүсвэрүүдээ нөхдөг байна.

6.Усан цахилгаан станц (УЦС) барих тухай

Хөрш орноос хамааралгүй дотооддоо урсгалтай голуудад УЦС барих шийдэлд хүрч, Завхан гол, Ховд голуудыг түшиглэн УЦС барихаар төлөвлөжээ.

Эхнийх нь 90мВт-ын хүчин чадал бүхий Эрдэнэбүрэнгийн УЦС-ын зээлийн хэлэлцээр шийдэгдэх шатандаа оржээ. 270 сая ам.долларын төсөвтэй энэ төслийн санхүүжилтийн 95%-ийг БНХАУ-ын Экспорт-Импорт банк /ЭКСИМ/-ны хөнгөлөлттэй зээлээр шийдвэрлэх ба барилга угсралтын ажлыг энэ хавраас эрчимжүүлэхээр төлөвлөсөн байна.

Удаах нь 30 мВт-ын хүчин чадалтай Байдрагийн УЦС. Энэ төслийн ТЭЗҮ батлагдсан бөгөөд санхүүжилтийг шийдвэрлэх талаар Унгарын талд санал тавьжээ.

Мөн 11 жил яригдсан Эгийн голыг түшиглэн 450 мВт-ын хүчин чадалтай УЦС барих төслийн холбогдох судалгааны ажлыг хийж, ОХУ-тай харилцан ойлголцолд хүрэх ажлыг 2024 онд хийхээр төлөвлөсөн байна.

Өнгөрсөн хугацаанд Азийн хөгжлийн банк /АХБ/ болон улсын төсвийн санхүүжилтээр 60 байршилд судалгаа хийж, үүнээс шигшсээр хамгийн оновчтой байршлуудыг сонгожээ. Эцсийн байдлаар ТЭЗҮ хийсэн байршил нь Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын нутаг дахь Ерөө голын дэргэд 100 мВт чадалтай ус хуримтлуурын станц барихаар болсон байна. Энэ төслийг 2025 оноос АХБ-ны 150 сая ам.долларын зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр болжээ.

Мөн Говьсүмбэр, Дундговь аймгийн төвд 200мВт цагийн багтаамжтай батарей хуримтлуурыг өрсөлдөөний зарчмаар, хувийн хөрөнгө оруулалтаар бариулахаар төлөвлөжээ. [40]

Эрчим хүчний салбарын томоохон бүтээн байгуулалт, техник технологийн шинэчлэлээс дурдвал:

Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд 10 МВт-ын нарны цахилгаан станцын төсөл:

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт 10 МВт-ын суурилагдсан хүчин чадал бүхий нарны цахилгаан станцын барилга угсралтын ажил 2022 оны 09 дүгээр сарын 22-нд эхлэн, 2022 оны 12 дугаар сарын 25-нд улсын комисс ажиллаж ашиглалтанд хүлээн авсан. Энэхүү 10 МВт-ын чадалтай цахилгаан станц нь 545 Вт-ын нэгж чадалтай 20,176 ширхэг нарны дэлгэц, 1250 кВт нэгж чадалтай 8 инверторийн байгууламжтай, жилд 19,5 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн сүлжээнд нийлүүлэх техникийн үзүүлэлттэй. “Алтай-

[40] Монголын уул уурхайн сэтгүүл 2024.06.03 https://www.mongolianminingjournal.com/a/73488 татсан: 2024.08.15

Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 35/10 кВ-ын Алтай дэд станцтай 6.5км урт 35 кВ-ын шугамаар холбогдсон.

800 МВт/200МВт.ц-ийн хүчин чадалтай эрчим хүч хуриmтлуурын систем:

“Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төсөл”-ийн хүрээнд Төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдон ажиллах 80 МВт-ын чадалтай, 200МВт.ц-ийн багтаамжтай эрчим хүч хуримтлуурын системийн барилга угсралтын ажил 2023 оны 04 дүгээр сарын 15-нд эхэлж 2023 оны 12 дугаар сарын 08-нд техникийн комисс ажиллан нэгдсэн сүлжээнд залгасан.

Улсын Их хурлаар 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг баталж зээлийн хэлэлцээрийг Азийн хөгжлийн банк болон Сангийн яам хооронд, Төслийн тусгайлсан дамжуулан зээлдүүлэх гэрээг Азийн хөгжлийн банк, Эрчим хүчний яам, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК хооронд тус тус байгуулсан.

10 МВАр-ын хүчин чадалтай хуурмаг чадлыг компенсацлах төхөөрөмж (SVG):

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем”-ийн 110/35/10 кВ-ын “Тэлмэн” дэд станцад 10 МВАр хүчин чадалтай хуурмаг чадлыг компенсацлах төхөөрөмжийг (SVG) суурилуулж сүлжээнд холбосон.

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” нь эх үүсвэрийн дутагдалтай, “Төвийн бүсийн нэгдсэн сүлжээ”-ээс алслагдсан тул ачаалал дамжуулах боломж сул, хүчдэлийн горим хүндрэлтэй ажилладаг систем юм. Хоногийн оргил ачаалал болон бага ачааллын цагуудад 110 кВ-ын хүчдэл 7-9 кВ-оор хэлбэлздэг.[41]

[41] Эрчим хүчний зохицуулах хороо |Эрчим хүчний статистикийн үзүүлэлтүүд 2023 https://online.fliphtml5.com/seigx/vutw/#p=97 татсан: 2024.08.15

Асуудал 4: “4.1.2. Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог нэгдмэл, үр нөлөөтэй, боловсронгуй болгох чиглэлд шаардлагатай эрх зүй, удирдлага, зохион байгуулалтын шинэчлэл хийнэ”

Тухайн асуудалтай холбоотой мэдээллийг эрдэмтдийн судалгаа шинжилгээ, мэдээлэл зэргийг түүвэрлэн бэлтгэлээ.

1. Г.Базарваань (УАБЗ, ССХ-ийн судлаач, дэд хурандаа), Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо, Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудал) 2022, 30-39 дүгээр тал

Үндэсний аюулгүй байдлын тогтолцоо бол үндэсний язгуур эрх ашиг сонирхол, аюул заналхийллийн харилцан үйлчлэлийг тодорхойлсон функциональ тогтолцоо байдаг. Үндэсний аюулгүй байдлын тогтолцоонд:

- Үндэсний аюулгүй байдлыг хангах хүчин- төрийн цэргийн байгууллага, түүн дотроо Зэвсэгт хүчин, хилийн цэрэг болон гамшгаас хамгаалах, хууль сахиулах чиг үүрэг бүхий бусад байгууллага, түүнчлэн хууль тогтоомжийн дагуу улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад оролцож буй улсын байгууллагууд;
- Үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгсэл- төрийн тухай мэдээллийг цуглуулах, бүрдүүлэх, боловсруулах, дамжуулах, хүлээн авах үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоонд ашигладаг технологи, түүнчлэн техник, программ хангамж, хэл шинжлэл, хууль эрх зүй, зохион байгуулалтын хэрэгсэл, түүний дотор үндэсний аюулгүй байдал, түүнийг бэхжүүлэх арга хэмжээг бэхжүүлэх харилцаа холбооны суваг багтдаг.

…Харин үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо бол аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүргийг төрийн бодлогын дагуу хэрэгжүүлдэг төр, засаг, төрийн захиргааны төв болон нутгийн удирдлагын төв байгууллага, тэдгээрийн мэдэлд байгаа бүтэц, хүч, арга хэрэгслийн цогц нэгдэл юм.


Монгол Улс Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тухай тогтолцооны тухай авч үзсэнээс Үндэсний аюулгүй байдлын тогтолцоог бүрхэгдүүлэн орхисон байдаг.

…Монгол Улсын тухайд өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай, аюулгүй байдлаа хангах эрх зүйн цөөнгүй баримт бичгийг боловсруулж, баталж заримыг нь шинэчлэн боловсруулж байна. Үүнээс үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог дан ганц түүнийг хангах тусгайлсан чиг үүргийн байгууллагын хүчин чадлаар хязгаарлах бус үүний дээр эрх зүйн баримт бичиг, тэдгээрийг хэрэгжүүлэх, сахин биелүүлэх нэгдмэл цогц хэмээн үзэх зөв.

2. П.Батжаргал (УАБЗ, ССХ-ийн судлаач, хурандаа), Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаа, Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудал) 2022, 39-49 дүгээр тал

…Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого-стратегийн баримт бичгийг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх тактикийг сонгох, хэрэгжүүлэх явцад нь хяналт тавих нь

үндэсний аюулгүй байдлыг хангах цогц арга хэмжээ юм. Үүнийг дараах зургаар хялбаршуулан харуулав.



3. *З.Болдбаатар (ҮБХИС-ийн профессор, Доктор (Ph.D)), "Үндэсний аюулгүй байдлыг хангах нэгдсэн бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох асуудалд", "Батлан хамгаалах салбарын эрдэм шинжилгээ судалгааны онол, арга зүйн сэтгүүл №33 (43) 2022", Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, 5-14 дүгээр тал*

…ҮАБЗ-ийн үйл ажиллагааны онцлог тал нь үндэсний аюулгүй байдлын бүрдэл хэсгүүд тус тусдаа бие дааж аюулгүй байдлаа хангах боломжгүй харин эдгээрийг нэгдсэн удирдлага, харилцан ажиллагааны зохицуулалтаар хангахад оршиж байгаа юм.



Нэгдсэн бодлого, эрх зүйн хүрээнд:

- Өнгөрч буй хугацаанд үндсэн хуульд хоёр ч удаа өөрчлөлтүүд орж, түүний үзэл санаануудыг аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох түүний үзэл санаануудыг удаашралтай байна. Улс орны аюулгүй байдал, язгуур эрх ашигтай холбоотой асуудлуудыг улс төржүүлэлгүй хурдан шуурхай шийддэг арга замуудыг цаашдаа бий

болгох шаардлага байна гэж харж байна. 2010 онд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал шинэчлэгдээд 10 гаруй жил болж байхад түүнийг ажил хэрэг болгож хэрэгжүүлэх ёстой “Үндэсний аюулгүй байдлын тухай” хууль өөрчлөгдөөгүй хуучнаараа байна.

- Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын бодлого, үйл ажиллагааны чиг үүргүүдийг хооронд нь нийцүүлж, үндэсний аюулгүй байдлын язгуур эрх ашгуудтай уялдуулах, аюулгүй байдлын эрх ашигт сөргөөр нөлөөлөх эрсдэлүүдийг байнга тооцож, урьдчилсан арга хэмжээнүүд авч, харилцан ажиллагааны төлөвлөлт хийж, байнга тодотгож байх шаардлага байна.
- Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын болон салбарын органик хуулиудад УАБҮБ болон Аюулгүй байдлыг хангах тухай хуулиудын үндсэн агуулгын үзэл санаа, мөн чанаруудыг суулгаж өгөх нь зүйтэй юм.
- Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуульд байгаа зөвлөлийн чиг үүргүүдийн заалтуудыг эргэн харж үзэж тодотгох нь зүйтэй гэсэн байр суурьтай байна. Учир нь нийгэм, гадаад орчны хувьсал өөрчлөлтүүд их хурдтай явагдаж, хувьсаж байна.
- УАБЗ-ийн бүтцийг 3 хүн байхаар хуульчилж өгсөн байдаг ба шаардлагатай тохиолдолд төрийн тэргүүний санал болгосноор тодорхой албан тушаалтнуудаар нэмж болохоор эрх зүйн үндэс тавигдсан байдаг. Ер нь Аюулгүй зөвлөлийн тухай хуульд зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал өөрчлөлт оруулна гэснийг цаашдаа өөрчилж төрийн тэргүүн өөрөө шийддэг байх талаар хуульчилж өгөх нь зүйтэй гэсэн саналтай байна.
- Цаашдаа УАБҮБ-ын хэрэгжилтийг хангах, улс орны хөгжлийг сайжруулж, хурдасгах зорилгоор Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийг Үндэсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн оронд боловсруулж гаргах нь зүйтэй байж болох юм гэж үзэж байна. Учир нь Аюулгүй байдал судлал, үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд дэлхий нийтэд эдийн засгийн аюулгүй байдлын асуудлыг тэргүүлэх зэрэгт тавьж, түүний хөгжил, боломжийг тооцон аюулгүй байдлаа хамгаалах, хангах асуудлуудыг авч үздэг хандлага тогтож эхлээд байна.
- Улсын Их Хурлаар оруулж хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа хуулийн төслүүд, стратегийн ач холбогдолтой том төсөл, хөтөлбөрүүд болон худалдан авалтын том гэрээ, хэлэлцээрүүдийг нэгдсэн чуулганаар орохоос өмнө УАБЗ дээр хэлэлцэж, үндэсний язгуур эрх ашгуудад хир нийцэж байгаа болон түүнээс гарах нийгэм, хүмүүнлэгийн болон байгаль орчны, үндэсний аюулгүй байдлын сөрөг үр дагаврыг үнэлж, дүгнэж саналаа хүргүүлж, шаардлагатай бол зогсоох хүртэл арга хэмжээ авч байх хэрэгцээ байсаар байна.
- УАБЗ-ийн ажил нь УАБҮБ, Аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хүрээнд тухайн цаг үеийн гадаад, дотоод орчны өөрчлөлтийг хурдан мэдэрч түүнд зохицож, уялдсан үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн төрийн нэгдсэн бодлогыг шуурхай гаргаж байх шаардлага байгаа нь одоо болж байгаа ОХУ, Украйны хоорондын хямрал, хоёр хөршийн хилийн хязгаарлалт, дэлхийн эдийн засгийн шок, цар тахлын дараах сэргэлт их удаан явагдах эсвэл хойшлогдох зэрэг нөхцөл байдлуудаас тодорхой харагдаж байна.

Бүтэц, үйл ажиллагааг боловсронгуй болгох зохицуулалтын хүрээнд:

- Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг хүлээсэн байгууллагуудын үүргүүдэд шинэ нөхцөл байдалтай холбогдуулан тодотгол хийж, асуудал шийдэх чадамжийг нь нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм.
- УАБЗ болон Засгийн газрын ажлын уялдаа холбоог шинэ шатанд гаргаж, уялдуулах, нэгдмэл зорилго, чиглэлтэйгээр тулгамдсан асуудлуудыг шуурхай шийддэг тогтолцоог бий болгох нь ихээхэн чухал гэж үзэж байна.
- Төр, орон нутгийн захиргааны байгууллагын бүтцэд үндэсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, үнэлэлт дүгнэлт өгч тодорхой санал боловсруулж байдаг энэ ажлыг хариуцсан албан тушаалтныг бий болгох, эсвэл энэ үүргийг хүлээсэн хүнийг сургаж бэлтгэх хэрэгцээ байна гэж харж байна. Өөрөөр

хэлбэл ҮАБЗ өөрийн бүтцийг орон нутагт бий болгож, зөвлөлийн шийдвэрийг заавал биелүүлдэг системийг бий болгох нь зүйтэй байх гэж үзэж байгаа юм.

- Цаашдаа бид эрсдэл, болзошгүй нөхцөл байдалд тулгуурласан судалгаа шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч түүнийг зөв таамаглаж, хариу шуурхай арга хэмжээ авч байх үйл ажиллагааны дэг журмыг бүтцэдээ бий болгох хэрэгцээ байж болох юм гэж үзэж байна. Ер нь улс орны хөгжлийн болон эдийн засгийн, стратегийн том ач холбогдолтой төсөл, хөтөлбөрүүд үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болох эрсдэлийн үнэлгээ хийж, түүний үр дүн, нөлөөг зөвлөлөөс хянаж шалгаж, тайлагнаж байвал зүгээр байгаа юм.
- ҮАБЗ-ийн өнгөрсөн хугацааны үйл ажиллагаа, сургамжаас харж байхад улс төрийн хүчний аливаа бодлого, үзэл санаанд хөтлөгдөх, улс орны хөгжлийн стратегийн том төслүүдийн үр дүнг зөвхөн санхүү, эдийн засгийн талаас нь харах зэрэг алдаатай зүйлүүд байсныг цаашид анхаарч иймэрхүү төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс хяналт тавьж анхаарч байх нь зүйтэй.
- ҮАБЗ зарим тохиолдолд ҮАБҮБ, ГБҮБ, Аюулгүй байдлыг хангах тухай хууль зэрэг баримт бичгүүдийн үзэл санаанд баригдаад, ҮАБ-ийн гол асуудлуудаа барьж авч, өргөн хүрээтэй уян хатан байдлаар ажиллаж чадахгүй тал байгааг цаашид анхаарч байх нь зүйтэй.
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн үйл ажиллагаанд Үндэсний аюулгүй байдлын бодлогыг “бодлого” талаас хянах, үзэл баримтлалын хэрэгжилтийг хангуулах “стратеги” боловсруулах, аюулгүй байдлын асуудлаар нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенциудын хэрэгжилт биелэлтийг тооцох, үндэсний аюулгүй байдлаа хангах чадавхыг бүрдүүлэх зэрэг асуудлуудад давхар анхаарч байх нь зүйтэй бөгөөд аливаа асуудлаар төрийн тэргүүн шийдвэр гаргах, олон нийтэд мэдээлэх зэрэг арга хэмжээнээс өмнө аюулгүй байдлын бодлогын зөвлөл хэлэлцсэний дараа төрийн тэргүүнээр батлуулж байх нь зүйтэй гэж үзэж байна.

Хяналт, хэрэгжилт, үр дүнгийн тухайд:

- Үндэсний аюулгүй байдлыг хангах чадавх яг ямар хэмжээнд байна, энэ үзэл баримтлалын хэрэгжилт ямар түвшинд байна, үзэл баримтлалын үзэл санаа Улсын Их Хурлаас баталж гаргадаг хуулиудад яаж тусгалаа олж байна, цаашид юунд анхаарах талаар ямар нэг дүгнэлт, үнэлгээ хийгдэж баримжаалах чиглэл тогтож бий болоогүй байна.
- Аюулгүй байдлын зөвлөлөөс аливаа асуудлыг шийдвэрлэх, хангуулахын тулд зөвлөмж гаргаж биелэлтийг нь хангуулдаг. Биелэлтийг хангуулах хариуцлагын тогтолцоо ихээхэн сул байгаад цаашид анхаарч хуульд энэ талаар тодорхой тусгах нь зүйтэй.
- Цаашдаа төрөөс батлан гаргасан аюулгүй байдлыг хангах талаарх хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн эдийн засгийн үндэслэл тооцоог сайн гаргаж, түүнийг хэрэгжүүлэх үйл явцыг санхүүжилт, эдийн засгийн төсвийн төлөвлөлттэй нь холбон авч үзэж байх нь зүйтэй юм. Учир нь өнгөрсөн хугацаанд аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалалтыг бэхжүүлэх талаар олон хөтөлбөр, төлөвлөгөө батлагдсаны биелэлтийг тооцоход санхүүжилт, төсвийн төлөвлөлтөөсөө болоод маш олон асуудал хэрэгжээгүй үлдсэн байдаг ба энэ байдал бусад салбарт мөн адил байгаа гэж харж байна.
- ҮАБЗ-ийн шийдвэрийг заавал биелүүлдэг байх системийг бий болгож, хяналтыг сайжруулах шаардлагатай ба энэ асуудлыг хариуцдаг, хяналт тавьдаг хүмүүсийг тусгайлан сургаж, бэлтгэх шаардлага байна гэж харж байна.
- Цаашдаа ПССХ-ийн бүтцэд Аюулгүй байдал судлалаар дагнасан судлаачдын тоог нэмэгдүүлэх, судалгаа хийх ажлын чиглэлүүдийг нь олон улсын амьдралын үйл явц, нөхцөл байдалтай уялдуулан уян хатан байдлаар маш тодорхой гаргаж өгч байх нь чухал байна гэдэг нь өнөөгийн үйл явцаас харагдаж байна.
- АБЗ-ийн дэргэд ССХ түшиглэн Аюулгүй байдлын сургалтын төв байгуулах, төрийн болон орон нутгийн албан хаагчдад зориулсан сургалтын материалууд бэлтгэн гаргах, сургалтыг орон нутагт газар дээр нь зохион байгуулах, аюулгүй байдлын асуудлаар эрдмийн зэрэг цол хамгаалж байгаа эрдэмтдийн бүтээл, мэдээллийн

баазыг нэгтгэн төвлөрүүлэх зэрэг ажлуудыг холбогдох сургууль, судалгааны байгууллагуудтай хамтран хийх шаардлага байсаар байна.

- Зөвлөлийн үйл ажиллагаанд байгаа нэг дутагдалтай тал бол манай нийгмийн амьдралын бодит байдлаас хөндий, бодит үнэн байдлыг сайн мэдэрч чадаагүй хэт ерөнхий байдлаар хандаад, улс орны эрх ашигтай холбоотой асуудлаар зоримог шийдвэр гаргахгүй байна гэсэн олон нийтийн шүүмж байгааг энэ дашрамд хэлэх нь зүйтэй.

\\

Асуудал 5: 4.3.1. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх, аюулгүй байдлын нөхцөл байдалд үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтүүдийг ҮАБЗ боловсруулна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны бүтэц, удирдлагын тухайд Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн зургаадугаар зүйлд "... Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон холбогдох албан тушаалтнаас бүрдэнэ ..." гэж, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн хоёрдугаар зүйлд "... Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалт нь хэрхэн хангагдаж байгаад хяналт тавих төрийн зөвлөлдөх байгууллага мөн ..." гэж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 4.2.1-д "... Үндэсний аюулгүй байдлыг хангах үүргийг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Засгийн газар, хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагууд, төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд гүйцэтгэнэ ..." гэж тус тус заасан байдаг.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.1 дэх хэсэгт төрийн нууцад хамааруулсан мэдээллийг зааж өгсөн, мөн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын хавсралтаар "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-ыг батлагдсан байна. Үүнд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Стратегийн судалгааны хүрээлэнгийн хүрээнд төрийн нууцад хамааруулах мэдээллийн жагсаалтыг гаргаж өгсөн. Жагсаалтын 18 дугаарт заасан "ҮАБЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын эх материал, холбогдох баримт бичгүүд (танилцуулга, илтгэх хуудас, баримтлах үндсэн чиглэл, шинжээчдийн дүгнэлт)" нь төрийн маш нууц зэрэглэлд хамаарна гэсэн байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл (ҮАБЗ) нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох хуулийн биелэлтийн явцыг хэлэлцэж дүгнэлт гаргах бүрэн эрхийг эдэлдэг.

ҮАБЗ-ийн Нарийн бичгийн дарга асан Ж.Энхбаяр "Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдал" онол практикийн асуудлууд эмхэтгэлийн өмнөх үгэнд "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх сонор сэрэмжтэй байх нь зөвхөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй төрийн байгууллагуудын ажил, үүрэг төдийгүй Монгол Улсын иргэн бүр, түүний дотор төрийн албаны бүх шатны албан хаагчид, аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдлэг, мэдээлэлтэй байж үндэсний аюулгүй байдлыг хангах үйлсэд бодит хувь нэмэр оруулах учиртай."[42] гэж өгүүлсэн байна.

Монгол Улсын оршин тогтнох баталгаа нь үндэсний аюулгүй байдлаа хангах явдал юм. Иймээс Монгол Улсын иргэн бүр үндэсний язгуур ашиг сонирхлыг бэхжүүлэх, хамгаалахад чиглэсэн төрийн хууль тогтоомж, бодлого шийдвэрийг баримталж явах нь үндэсний аюулгүй байдлыг хангах гол үйл ажиллагаа юм.

[42] ҮАБЗ-ийн Ажлын алба, Стратеги Судалгааны хүрээлэн. "Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдал" онол практикийн асуудлууд., 3 ху, 2022 он

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж

- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль;
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль;
- Төрийн болон албаны нууцын тухай хууль;
- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол;
- Түлш эрчим хүчний салбарын талаар авар зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2010 оны 72 дугаар тогтоол https://legalinfo.mn/mn/detail?lawId=6622;
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол;
- “Шинэ сэргэлтийн бодлого” УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоол Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол., Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал;
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоол, Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт;
- https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390082551211&showType=1;
- “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө” УИХ-ын 2022 оны 23 дугаар тогтоол https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530575998941.

Ном, товхимол, эрдэм шинжилгээний өгүүлэл

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудлууд) 2022 УБ;
- Шинжлэх ухааны танин мэдэхүйн арга судлал Б.Өлзийхуяг, Т.Намсрай 2022 УБ;
- National Security Theory and Practice, Waldemar Kitler 2021 Warsaw;
- Г.Базарваань (ҮАБЗ, ССР-ийн судлаач, дэд хурандаа) “Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо” Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудал) 2022;
- П.Батжаргал (ҮАБЗ, ССХ-ийн судлаач, хурандаа), “Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаа” Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудал) 2022;
- З.Болдбаатар (ҮБХИС-ийн профессор, Доктор (Ph.D)), “Үндэсний аюулгүй байдлыг хангах нэгдсэн бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох асуудалд”, “Батлан хамгаалах салбарын эрдэм шинжилгээ судалгааны онол, арга зүйн сэтгүүл №33 (43) 2022”, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн;
- С.Түвшинжаргал (ҮАБЗ, ССХ-ийн судлаач) “Даяаршил ба эдийн засгийн аюулгүй байдал” Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудал) 2022;
- Д.Батмөнх (ҮАБЗ, ССХ-ийн судлаач), Ц.Товуудорж (Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч, доктор) “Эдийн засгийн аюулгүй байдалд тулгарч буй эрсдэл, сорилтууд” Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (онол, практикийн асуудал) 2022.

Цахим эх сурвалж

- Монгол Улсын эрчим хүчний үр ашиг, хүртээмж, түүнд хийсэн бүтцийн шинжилгээ, ҮСХ, 2019 он;
  ;https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=LMDI_decomposition_analysis_of_energy-Mongolia.pdf&ln=Mn;
- Ногоон эдийн засгийн бодлогын дүн шинжилгээ:Монгол Улс, БОАЖЯ, 2018 он;
- https://ecrc.mn/media/ecrc/content/%D0%91%D1%83%D1%81%D0%B0%D0%B4_%D1%81%D1%83%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%B0/gepa_mon.pdf ;
- Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2023: https://online.fliphtml5.com/seigx/vutw/#p=1;
- Эрчим хүчний яамны цахим хуудас https://energy.gov.mn/c/1544;

- Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд эрчим хүчний салбарын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайлан https://energy.gov.mn/uploads/files/%D0%A5%D0%A8%D2%AE%20%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD%20%D0%B6%D0%B8%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%8D%D1%86%D1%8D%D1%81%20%D1%8F%D0%B0%D0%BC%20%D0%B2%D0%B5%D0%B1(1).pdf;
- Эрчим хүчний яамны хяналтад буй хууль тогтоомж, тогтоолын шийдвэрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /2021 оны эцсийн байдлаар/: https://energy.gov.mn/uploads/files/%D1%85%D1%83%D1%83%D0%BB%D1%8C%20%D1%82%D0%BE%D0%B3%D1%82%D0%BE%D0%BE%D0%BC%D0%B6-2021%20%D0%BE%D0%BD(1).pdf;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам:https://mmhi.gov.mn/%D0%B7%D0%B0%D1%81%D0%B3%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B3%D0%B0%D0%B7%D1%80%D1%8B%D0%BD-%D2%AF%D0%B9%D0%BB-%D0%B0%D0%B6%D0%B8%D0%BB%D0%BB%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD%D1%8B-%D1%85%D3%A9%D1%82%D3%A9%D0%BB/;
- “Эрчим хүчний реформ нь судалгаанд суурилсан цогц шийдэл байх ёстой” Эрчим хүчний зохицуулах хорооны дарга, Монгол Улсын зөвлөх инженер Э.Түвшинчулуунтай хийсэн ярилцлага: https://news.mn/r/2744583/.